

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН



ШИНЭ НОМЫН

2017.05.08

№ 02

ЭМХЭТГЭСЭН:

Номзүйч М. Кунай

Номзүйч М. Намжилмаа

Электрон каталог:
<http://catalog.num.edu.mn>


ГАРЧИГ

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ	3
ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН	3
ГЕОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН	4-5
ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН	5
ЕРӨНХИЙ ГЕНЕТИК, АШИГТ МАЛТМАЛ	5-6
СҮҮ, ЦАГААН ИДЭЭ, ЖИМС ЖИМСГЭНЭ	6-7
МАЛ АЖ АХУЙ	7
АНАГААХ УХААН, ЭРҮҮЛ АХУЙ	7-8
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН, СОЦИОЛОГИ	8-9
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН	9-13
ЭДИЙН ЗАСАГ	13-15
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН	15
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	15-18
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ	18-19
БОЛОВСРОЛ СУДЛАЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙ	19-20
МУЗЕЙ СУДЛАЛ	20-22
ХЭЛ ШИНЖЛЭЛ	22-23
АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ	23
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ	23-27
УРАН ЗОХИОЛ	27-29
ШАШИН СУДЛАЛ, ЁС СУРТАХУУН	29-30
СЭТГЭЛ СУДЛАЛ, НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ	30
ОРОС, АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ НОМНУУД	30-32

Товчилсон үгийн тайлбар:

БУН унш-Байгалийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №307/
НУН унш-Нийгмийн ухааны номын уншлагын танхим /Хич-2, №213/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд /Хич-2, №135/
ГФ-Гадаад фонд /Хич-2, №136/
Лав.-Лавлагааны фонд /Хич-2, №108/
БС- ийн номын сан /Хич-5, №505/
ОУХНУС-ийн номын сан /Хич-5, №304/
ХЗС-ийн номын сан /Хич-3, №205/
ХШУИС-ийн номын сан /Хич-3, №113/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-7, №115/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-1, №110/
ШУС-БУС-ийн номын сан /Хич-3, №221/
ШУС-НУС-ийн номын сан /Хич-2, №219/
ШУС-ХУС-ийн номын сан /Хич-2, №334/

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ



Дашням Б. **Хойч үедээ юу үлдээх вэ?...** / Хян. З.Батжаргал.- УБ.: Адмон, 2016.- 87х.- ISBN 978-99978-4-432-3.

Уур амьсгалын тухай ойлголт, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, уур амьсгалын талаар улс гүрнүүдийн болон олон улсын хэмжээнд явуулж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар энэ номонд энгийн хэллэгээр ойлгомжтой бөгөөд дэлгэрэнгүй бичсэн ба “Хойч үедээ бид юу үлдээх вэ?”, “Эд хогшил, байшин барилга, алт уу эсвэл эрүүл сайхан эх дэлхийгээ юу?” гэдэг асуудлуудыг нийт уншигчиддаа дэвшүүлжээ.

20.1

Д-39

/БУН унш-3ш/

T-18808-18809

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Биндэрьяа М. ба бус. **Эмийн ургамлаас биологийн идэвхт бодисууд ялгах аргачлал** / М.Бөхчулуу, А.Гарамжав; Хян. Д.Найдан; Эмхт. Н.Гэрэлсүрэн.- УБ.: Тоонотпринт, 2016.- 164х.- ISBN 978-99962-862-2-3.


Эмийн ургамал судлаачид, химичид, эм зүйн төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын оюутнууд, эм зүйч нарт зориулагдсан энэ номонд эмийн ургамлаас биологийн идэвхт бодисуудыг ялгах, өөр хооронд нь салгах, таньж тодорхойлох, тоон тодорхойлолт хийхэд нимгэн үеийн, цаасан, баганат, хий-шингэний хроматограф, хемилюминесценц, масс-спектрийн гэх мэт аргуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

24.239

Б-48

/БУН унш-5, ГНОФ-2ш/

T-18709-18711



Норжинбадам С., Нордов Э. **Англи-Монгол хими, хими технологийн толь** / Ред. Н.Амгалантайван.- 2 дахь хэвл.- УБ.: ХҮСТ., 2013.- 503х.- ISBN 978-99973-46-26-1.

Энэхүү толь бичгийн 2-р хэвлэлийг бэлтгэхдээ анхны хэвлэлийн зарим үгс, нэр томъёоны орчуулгийг тодотгож, монгол орчуулгийн үг, үгсийн алдааг нарийвчлан хянаж, химийн шинжлэх ухаанд шинээр орж ирж байгаа үгс, нэр томъёог нэмж оруулжээ.

24я2

Н-74

/БУН унш-3ш/

Б-24842-24843

Органик хими: Сурах бичиг / Б.Бямбагар, М.Наранцэцэг, Д.Хандмаа ба бус.; Ред. Д.Хандмаа.-УБ.: ШУТИС ХГ., 2017.- 338х.- ISBN978-99929-2-727-4.


Энэхүү сурах бичгийг “ШУТИС-ийн бакалаврын түвшний математик, физик, химийн ерөнхий суурь хичээлүүдийн сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” төслийн хүрээнд бичиж, ХШУС-ийн ном сурах бичгийн арга зүйн зөвлөлийн шийдвэрээр хэвлүүлжээ. Энэ ном нь 17 бүлэгтэй бөгөөд органик химийн салбар ухааны суурь онол, органик бодисуудын байгалийн эх үүсвэр, түүхий эдээс бүтээгдэхүүн гарган авах аргууд, органик бодисын физик ба химийн шинж чанар, тэдгээрийн хэрэглээний талаар өгүүлсэн ба хүснэгт, зураг тайлбартай ажээ.

24.2


О-41

/БУН унш-7ш/

T-18799-18801



ГЕОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Волостных Г.Т. **Аргиллитжиж хувирсан чулуулаг ба хүдэржилт** / Орч. Д.Гарамжав, Т.Мөнхбат, А.Ундрахтамир; Хян. Ж.Лхамсүрэн.- УБ.: ВСІ., 2015.- 278х.- ISBN 978-99973-63-61-9.

Энэхүү орчуулгын эмхэтгэлд аргиллитжиж хувирсан чулуулгийн геологи ба геохимийн нөхцөлүүд, найрлагын онцлогууд, бүслүүржилт, хүдэр агуулалтын тухайд болон аргиллизацд орсон чулуулгийг судлах аргачлал аргууд, тэдгээрийн бусад хүдэр орчмын метасоматитуудтай хэрхэн харилцан уялддаг талаархи өргөн хүрээний мэдээллүүдийг нэгтгэн дүгнэжээ. Мөн зэсийн порфир, ховор металл алт-мөнгө агуулсан холимог металл болон мөнгөн усны ордуудын талаархи зохиогчийн материалуудаас гадна хүдэр орчмын аргиллизац хувиралтай холбоотой янз бүрийн асуудлууд хамрагдсан 500 гаруй бүтээлүүд дэх мэдээллийг нэгтгэж оруулсан байна.

26.31

В-68

/БУН унш-7ш/

Б-24740-24742

Гарамжав Д. ба бус. **Газрын ховор шороон элементийн эрдсүүд ба геохимийн онцлог**: ГХШЭ-Иттри ба лантаноидууд: Гарын авлага / С.Жаргалан, О.Одбаяр; Хян. Л.Баярмандал.- УБ.: ВСІ., 2015.- 132х.- ISBN 978-99973-63-62-6.



Хорин нэгдүгээр зууны технологийн хөгжлийн гол түүхий эд гэгдэж байгаа газрын ховор шороон элементийн тархалт, түүний хүдэржилт, эрдсүүдийн геохимийн онцлог, судалгаа, химийн болон физикийн шинж чанарууд, хэрэглээ, зах зээлийн талаар энэ номонд цэгцтэй, ойлгомжтой өгүүлжээ. Энэхүү гарын авлагыг их дээд сургууль, коллежийн оюутнууд, магистрантууд болон ашигт малтмалын эрлийн геологичдод зориулан гаргажээ.

26.30я7

Г-24

/БУН унш-7ш/

Т-18704-18706



Жаргалан С. ба бус. **Метал ашигт малтмал** / Б.Энхжаргал, Д.Алтанхуяг; Ред. Д.Гарамжав, Г.Сэрсмаа.- УБ., 2017.- 276х.- (ШУТИС. Геологи, уул уурхайн сургууль).- ISBN 978-99978-5-708-8.


Монгол орны эрдэс баялгийн салбарын оюутан залуучуудад метал ашигт малтмалын үндсэн ойлголт, тэдгээрийн ангилал, хэрэглээ, хүдрийн голлох эрдсүүд, ордуудын гарал үүслийн болон үйлдвэрлэлийн төрлүүд, тухайн төрөл тус бүрд хамаарах дэлхийн сайн судлагдсан ордуудын геологийн тогтоц, хүдрийн онцлог, ашигт малтмалын нөөц, баялгийн талаарх ухагдахуунуудыг өнгөт зургийн хамт дэлгэрэнгүй тайлбарлажээ.

26.341

Ж-31

/БУН унш-7ш/

Т-18802-18804



Мөнхтоого Л., Эрхэмбаяр М. **Шатах ашигт малтмалын геологийн үндэс** / Хян. Д.Гарамжав.- УБ., 2014.- 292х.

Энэ номны эхний хэсэгт шатах ашигт малтмалын тухай, хоёрдугаар хэсэгт Монгол орны шатах ашигт малтмал /нүүрс, шатдаг занар, газрын тос/-ын тухай судалгааны дүгнэлтүүдийг гаргаж, энэхүү дүгнэлтүүдээ үндэслэж монгол орны нутаг дэвсгэрт шатах ашигт малтмалыг эрж хайх зөвлөмжүүдийг гуравдугаар хэсэгт оруулж, Монгол орны нутаг дэвсгэрт тархсан шатах ашигт малтмалын судалгааны өнөөгийн түвшинд,

үйлдвэрлэлд ашиглаж болохоор онолын санаануудыг дэвшүүлжээ.

26.325

М-81

/БУН унш-7ш/

Т-18695-18697

Ухнаа Г. ба бус. **Шороон ордын хайгуул:** Гарын авлага / П.Нарантуяа, Б.Алтанзул; Ред. С.Жаргалан.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 69х.- ISBN978-99978-57-07-1.

ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулийн геологи, ашигт малтмалын эрэл хайгуулын мэргэжлээр бакалавр зэрэг горилон төгсч буй ирээдүйн геологичдыг, шороон ордын хайгуулын аргачлалд мэргэшүүлэн дадлагажуулах зорилгоор боловсруулсан энэ номонд шороон ордын хайгуулын дадлагын ажлын хураамж, хайгуулын план, зүсэлтүүд байгуулах, сорьцын агуулга ба дундаж агуулга тодорхойлох, сорьцын угаалга ба үлээлтийн хяналт, элсний ширхэглэлийн найрлага тодорхойлох, шороон ордын нөөц тооцоолох аргуудын талаар өгүүлжээ.

26.3я7


У-61

/БУН унш-7ш/

Б-24773-24775



ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН



Батболд Д. **Монгол орны байгалийн гайхамшиг:** Уул нурууд, говь, нуур, гол ус, тал хээр, агуй, галт уул: Сэдэвчилсэн зурагт лавлах / Ред. Ш.Шагдар.- 2 дахь хэвл.- УБ.: Сэлэнгэпресс, 2016.- 288х.- ISBN 978-99962-4-371-4.

Мөнх цаст уулс, говь, нуурууд, гол ус, үзэсгэлэнт уулс хэмээн 6 бүлэгт хуваан сэдэвчилсэн энэхүү зурагт лавлах номонд 100 гаруй газрын тайлбар таниулга, 700 орчим гэрэл зураг, 300 орчим газрын байршил /GPS/ солбицлыг багтаасан бөгөөд эх дэлхий, цэнхэр гаригаа чин сэтгэлээсээ хайрладаг, Монгол орны үзэсгэлэнт онгон, тансаг байгалийг хүсэгч хүн бүхэнд энэ номыг зориулжээ.

26.89(1)я6

Б-33

/БУН унш-6, Лав-1ш/

Т-18686-18688

Дэлхий: Дэлгэрэнгүй зурагт лавлах / Ерөн. ред. Жеймс Ф.Лахр, Жеффрей Е.Пост, Д.Түвшинбаяр; Орч. А.Амгалан, Д.Батмөнх, Т.Мөнгөншагай ба бус.- УБ.: Монсудар, 2014.- 528х.- ISBN 978-99973-1-087-3.

Сүүлийн үеийн мэдээллээр шинэчлэгдсэн, шилдэг борлуулалттай, энэхүү дэлгэрэнгүй зурагт лавлах нь манай гарагийн уулын оройгоос эхлээд далай тэнгисийн ёроол хүртэл, өмнөд туйлаас хойд туйл хүртэл нарийвчлан шинжилсэн гайхамшигт судалгааны үр дүн юм. Энэхүү лавлах ном нь дэлхий гараг, эх газар, далай-тэнгис, агаар мандал, дэлхийн тектоник гэсэн 5 бүлэгтэй ба манай гарагийн бүх л төрх байдлыг сэтгэл догдлуулам гэрэл зураг, тайлбартайгаар өгүүлжээ.

26.89(0)я6

Д-89

/БУН унш-7ш/


Т-18669-18671



ЕРӨНХИЙ ГЕНЕТИК

Цэндсүрэн Ц., Ариунтуул Ц. **Генетик:** Ген ба геном / Ред. Г.Саранцэцэг, Ч.Гантигмаа.- УБ.: Мелон, 2016.- 146х.- (ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн).- ISBN 978-99962-62-44-9.

Их, дээд сургуулийн оюутан болон шинжлэх ухааны салбарын ажилтан нарт зориулагдсан



энэхүү ном нь генетикийн үндсэн зүй тогтол, молекул генетик, ДНХ /Дезоксирибонуклейны хүчил/ технологи, бөөмийн бус удамшил, микроорганизмын генетик, амьтан ба ургамлын генетик гэсэн 6 бүлэгтэй ба генетикийн шинжлэх ухааны үндсийг ойлгоход хялбар хэлбэрээр, зургийн тайлбартайгаар оруулж өгчээ.

28.04

Ц-95

/БУН унш-7ш/

T-18701-18703

АШИГТ МАЛТМАЛ

Насанбуян Г., Базар В. **Ашигт малтмал баяжуулах технологийн үндэс:** Сурах бичиг / Ред. Я.Гомбосүрэн.- Дархан: Мөнхийн үсэг, 2011.- 246х.- ISBN 978-99929-1-742-3.

Ашигт малтмал, эрдсийн тухай ерөнхий ойлголт, тэдгээрийн гравитаци, соронзон, цахилгаан, флотаци баяжуулалтын үндсэн аргууд, хэрэглэх хүрээ, баяжуулалтын тоног төхөөрөмжүүдийн хийц бүтэц, ажиллагаа, ашиглалтын зорилгын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн энэхүү сурах бичиг нь анхдагч боловсруулалтын уул уурхайн бүх чиглэлийн ажиллагсад, геологи, уул уурхай, ашигт малтмалын боловсруулалт, металлург, хими технологийн мэргэжлээр суралцаж буй оюутан, судлаач нарт зориулагджээ.

33.4я73

H-32

/БУН унш-7ш/

T-18698-18700



СҮҮ, ЦАГААН ИДЭЭ, ЖИМС ЖИМСГЭНЭ



Дамдинсүрэн Л. **Сүү цагаан идээний шинжлэх ухаан, технологийн тайлал.**- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- ISBN 978-99973-2-280-7.

Таван хошуу малын сүүг боловсруулж, олон нэрийн цагаан идээ бэлтгэдэг монголчуудын уламжлалт мэдлэгийн мөн чанарыг сүүний төрөл, найрлага, физик-хими, технологи, биологийн шинж чанарын онцлогтой уялдуулан шинжлэх ухаан технологийн үүднээс тайлбарлаж мөн түүнчлэн цагаан идээний хуваарилалт, түгээлтийн оновчтой сүлжээ буй болгох зэргээр сүүний аж үйлдвэрийн хөгжлийг төсөөлжээ. Энэ номыг сүү, цагаан идээний судлаачид, эрдэмтэд, үйлдвэрлэл эрхлэгчид, технологийн магистр, докторын түвшний суралцагсад болон оюутнуудад зориулжээ.

36.95

Д-27

T-18684-18685



Насанжаргал Д. ба бус. **Монгол орны жимс жимсгэний салбарын лавлах** / Б.Нинж, Д.Ичинхорлоо; Ред. Д.Насанжаргал, Б.Нинж.- УБ.: Сэлэнгэпресс, 2014.- 614х.- ISBN 978-99962-4-349-3.

Энэ номонд Монгол орны жимс жимсгэний салбарт төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, энэ салбарт ажиллаж мэдлэг чадвараа зориулсан жирийн ажилтан, эрдэм бүтээл туурвисан мэргэжилтэн эрдэмтэд, аж ахуй нийгэм төрийн 100 гаруй зүтгэлтний намтар, дурсамж, аж ахуйн нэгж байгууллагын товч танилцуулга мөн монгол оронд ургадаг байгалийн жимс жимсгэний хамгийн өргөн ба ховор тархац, тарималжуулсан зарим ургамлууд, тэдгээрийн тархац, нөөц, биологи-морфологийн онцлог, хэрхэн ашиглаж хэрэглэх, үржүүлэг, жимст цэцэрлэгт хэрэглэгдэх багаж хэрэгсэл, жимсгэний хураалт, үйлдвэрлэл, жор, орцын норм, жимс жимсгэнд хор хөнөөл учруулдаг 41 зүйлийн шавьж, 23 зүйлийн өвчин, 5 зүйл шувуу, 7 зүйл мэрэгч амьтадын талаар

дэлгэрэнгүй өгүүлжээ.

42.35(1)я2

Н-32

/БУН унш-2ш/

T-18707-18708

МАЛ АЖ АХУЙ

Болдбаатар Ш. **Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам** / Хян. О.Үржин.- УБ., 2016.- 162х.- ISBN 978-99962-3-983-0.


Байгалийн аюулт үзэгдэл зудын эрсдэлийг бууруулах менежментийн онолын талаар өгүүлэх энэ номонд гамшгийн болон зудын эрсдэлийн менежмент, зудын эрсдэлийн үнэлгээний арга зүй, монгол орны зудын эрсдэлийн менежментийн өнөөгийн байдал, зудын сургамж, бэлчээр ашиглалт, өвс тэжээлийн бэлтгэл, тээвэрлэлтэнд хийсэн судалгаа, зудын эрсдэлийн менежментийн нэгдсэн удирдлага, бүтэц зохион байгуулалтын загвар, эрсдэлийг бууруулах стратегийг тодорхойлох, менежментийг хэрэгжүүлэх талаарх асуудлуудыг хөнджээ. Энэ бүтээлийг судлах уншигч та бүхэн гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн онол, практикийн мэдлэгээ бататгахын зэрэгцээ судалгаа, шинжилгээний ажилдаа арга зүй болгон ашиглаж болох ажээ.

45+68.9

Б-54

/БУН унш-7ш/

T-18692-18694



Лааган Б. **Монгол тэмээний түүхэн өв, соёл** / Хян. Д.Баттогтох.- УБ.: Эдмаркет, 2017.- 120х.- ISBN 978-99978-0-286-6.

Залуу үеийнхэнд монгол тэмээний түүх, өв соёлоос нь танин мэдүүлэх, сурталчлах зорилгоор бичсэн энэ номонд тэмээний төрлийн өвөг, тэдгээрийн тархалт, зэрлэг тэмээ буюу хавтгай, монгол тэмээ, тэмээн жин түүний өв соёл, төрөөс тэмээ, тэмээчдийг онцгойлон хүндэтгэж ирсэн түүхийн улбаа, тэмээ нь аман ба бичгийн зохиол мөн урлагийн бүтээлүүдэд хэрхэн мөнхөрсөн тухай өгүүлжээ.


46.2(1)

Л-10

/ШУС-НУС-1ш/

Б-24799-24801

АНАГААХ УХААН, ЭРҮҮЛ АХУЙ



Бямбасүрэн С. **Сэтгэцийн эмгэг судлал: Сурах бичиг** / Ред. Л.Эрдэнэбаяр, З.Хишигсүрэн.-2 дахь хэвл.- УБ.: Сэлэнгэпресс, 2013.- 830х.- ISBN978-99962-4-098-0.

“Сэтгэцийн эмгэг судлал”, “Сэтгэцийн эрүүл мэнд” хэмээх шинжлэх ухааныг судалдаг их сургууль, коллежийн оюутнууд, эмч сувилагч, хуульч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарт зориулагдсан энэхүү сурах бичиг нь 14 хэсэг, 67 бүлгээс бүрдэх ба 1-33 дахь бүлэгт ерөнхий сэтгэцийн эмгэг судлал, үлдсэн 34-67 дахь бүлгүүдэд тусгай сэтгэцийн эмгэг судлалын асуудлуудыг тусгажээ. Мөн түүнчлэн эмнэл зүйн харилцаа, ярилцлага авах арга техник, сэтгэцийн эмгэг судлал дахь ёс зүй, сэтгэл зүйн ба эрх зүйн зарим асуудал, бэлгийн төрх ба бэлгийн эмгэгүүд гэсэн сэдвүүдийг шинээр нэмж оруулжээ.

56.14

Б-98

/НУН унш-4, ГНОФ-3ш/

T-18712-18714

Цагаан Д., Намбар Б. **Нөхөн сэргээх эмчилгээ, рашаан сувилал: Сурах бичиг** / Ред. Ц.Мухар.- УБ.: Соёмбо принтинг, 2014.- ISBN 978-99962-2-766-0.



Энэхүү сурах бичигт нөхөн сэргээх болон рашаан эмчилгээний хөгжлийн төлөв, нөхөн сэргээх эмчилгээний төрөл, эмгүй ба хануур хорхойн эмчилгээ, хувь хүн өөрийнхөө биеийг чийрэгжүүлэх ухаан, эрүүлжүүлэх дасгал, иллэг, физик эмчилгээ, гүүний саам айрагний эмчилгээ, рашаан ба шавар эмчилгээ, дэлхийн хүн амын наслалт ба нөхөн сэргээх эмчилгээний талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

53.54я73

Ц-12

/БУН унш-7ш/

Б-24737-24739



Эрдэнэбаяр Л. **Донтолтын анагаах ухаан: Аддиктология** / Хян. М.Амбага.- УБ.: Сэлэнгэпресс, 2016.- 510х.- ISBN 978-99973-49-66-8.

Монгол улсын гавьяат эмч, доктор, профессор, академич Л.Эрдэнэбаяр энэ номондоо донтох эмгэг, түүний төрөл зүйлүүд, монголчуудын мансууралтай тэмцэж ирсэн түүхэн уламжлал, согтуурал, архидалт, архинд донтох эмгэгийн тархалт, түүний эмнэлзүй, эмийн бус эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, сэтгэл заслын эмчилгээ, хүн амд үзүүлэх наркологийн тусламж, далд ухамсар ба энергийн хүрд, ялан дийлэх сэтгэхүйн талаарх асуудлуудыг хамруулсан бөгөөд мөн түүнчлэн донтолтын анагаах ухааны нэр томъёоны тайлбарыг хавсаргажээ.

56.14

Э-73

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24749-24751



Эрдэнэцэцэг Б. **Невроз-Стресс** / Ред. Ш.Зоригоо.- УБ.: Финпак, 2016.- 104х.- ISBN 978-9973330-10.

Энэ номонд Невроз өвчин гэж юу вэ? Яагаад үүсч байна? Манайд үүнийг үүсгэгч шалтгаан байна уу? Энэ өвчний үед гарах онцлог шинж тэмдэг ба неврозоор өвчлөхгүй байх боломж байна уу? зэрэг асуудлуудыг хөндөж тайлбар өгөхийг зорьжээ. Үүний зэрэгцээ манайд байгаа невроз өвчний талаар хийгдсэн судалгаа онцлог тохиолдлуудыг заримаас нь жишээ болгож

оруулсан байна.

56.12

Э-73

/НУН унш-2ш/

Б-24735-24736

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН, СОЦИОЛОГИ

Ганхуяг Д. **Судлаачдад өгөх зөвлөмж: Нийгэм-түүхийн онолууд** / Ред. Т.Доржсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 199х.- ISBN 978-99973-58-44-8.

Манай оронд төрөл бүрийн судалгааны ажил их явуулах болов. Судалгааны чиглэл, сэдэв байхаас үл шалтгаалан практикт судалгааны мэдээлэл цуглуулах нь их хүнд ажил байдаг. Зарим хүмүүс анкет барьж байгаад хүмүүсээр бөглүүлэх шиг амархан юм байхгүй гэж ойлгодог. Судалгааны мэдээлэл цуглуулахад гаргасан алдаа нийт судалгааны ажлын үр дүнд их муугаар нөлөөлөх бөгөөд хожим нь үүнийг засах ямар ч боломж байдаггүй. Ер нь судалгааны мэдээлэл цуглуулах ажлын арга зөвлөмж тун ховор байдаг. Иймээс зохиогч манай оронд судалгаа явуулсан өөрийн болон нөхдийн олон жилийн практик судалгааны ажлын туршлагыг энэхүү номондоо эмхтгэн оруулжээ.

60в7

Г-23

/НУН-унш-3, ШУС-НУС-5ш/

Б-24807-24808



Мөнх-Эрдэнэ Г., Чулуунбат П. **Нийгэм-соёлын хүн судлалын удиртгал** / Ред. Д.Бум-Очир, Г.Баттогтох.- УБ.: МУИС., 2017.- 242х.- ISBN 978-99978-0-214-9.



Хүн судлал буюу антропологи (anthropology) нь хүнийг өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагийн хэмжээст төдийгүй бөмбөрцгийн бүхий л хэсэгт байгаа жишээ баримтад тулгуурлан судалдаг ухаан юм. Антропологи судлаачид тэр дундаа уг мэргэжлээр суралцаж буй оюутнууд гадаад хэл дээрх номуудыг түлхүү ашигладаг ба энэхүү шинжлэх ухааны талаар гарсан монгол хэл дээрх ном өдий хүртэлх хугацаанд хэвлэгдэн гараагүй шалтгааны улмаас зохиогчид энэхүү бүтээлээ туурвиж түүндээ хүн судлалын үндсэн ойлголт, эдийн засаг болон ураг төрлийн тогтолцоо, нийгмийн зохион байгуулалт болон хүчний тогтолцоо, хүн судлалын хэрэглээ, ёс зүй гэсэн агуулгуудыг багтаажээ.


60.5+71.1

М-81

/НУН-унш-7, ШУС-НУС-10ш/

Т-18761-18763

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Гу Бан. **Баруун орны шастир** / Орч. Ба.Батжаргал; Эрхл. Д.Эрдэнэбаатар.- УБ.: Удам соёл, 2015.- 84х.- ISBN 978-99973-73-48-9.

Залуу судлаач Ба.Батжаргалын орчуулсан энэхүү бүтээл нь Монголын эртний түүх, тэр дундаа Хүннү, Сяньби, Ухуаньчуудын түүхийг судлаж буй уншигчдад зориулагдсан бөгөөд энэ номонд “Баруун орны шастир”-ийн дээд, доод бүлгийг хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Г-66

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18750-18752

Гу Ван. **Хан улсын бичиг, Хүннүгийн шастир** / Орч. Ба.Батжаргал; Ред. П.Дэлгэржаргал.- УБ.: Удам соёл, 2016.- 164х.- ISBN 978-99973-3-578-4.



“Хан улсын бичиг, Хүннүгийн шастир” нь Сы ма Чянь-ий “Түүхэн тэмдэглэл хүннүгийн шастир”-ын дараа орох Хүннү гүрний тухай түүхэн сурвалж юм. Залуу судлаач Ба.Батжаргал “Хан улсын бичиг, Хүннүгийн шастир” бүтээлийг хятад хэлнээс орчуулсан бөгөөд хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Г-66

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18753-18755



Кузьмин Ю.В. **П.А.Бадмаев-эрдэмтэн, дипломатч, улс төрч** / Орч. М.Зулькафиль; Ред. С.Чулуун, В.В.Свинин.- УБ., 2014.- 222х.

Энэхүү нэг сэдэвт зохиолд өөрийнхөө үйл хэрэг, шинэ санаачлагаараа маш олон зүйлийн жинхэнэ анхдагч байсан, Оросын хаант засгийн улс төрийн томоохон зүтгэлтэн, анхны төвдийн анагаах ухааны эмч, дипломатч П.А.Бадмаевын /1851-1920/ үйл ажиллагааг шинжлэх ухааны үүднээс тодорхойлж, үнэлэлт өгөхийг оролджээ. Зохиогч гол анхаарлаа П.А.Бадмаевын амьдрал ба үйл ажиллагааны талаар бага судлагдсан асуудалд хандуулжээ. П.А.Бадмаевын амьдрал, үйл ажиллагааны талаар янз бүрийн үндэслэлгүй санал, хувилбар дэвшүүлсэн нийтлэлүүд өнөөдөр хүртэл маргаан, үл ойлголцол төрүүлсээр байгаа ажээ.

63.3(2)-8

К-89

/НУН унш-3ш, ШУС-НУС-2ш/

Т-18759-18760

Лиү шү. **Хуучин Тан улсын бичиг** / Орч. Ба.Батжаргал; Ред. Д.Эрдэнэбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 170х.- ISBN 978-99978-4-271-8.



Хуучин тан улсын бичиг нь үндсэн бүлэг буюу хаадын намтар 20 бүлэг, ойллого 30 бүлэг, шастир 150 бүлэг буюу нийтдээ 200 бүлгээс бүтжээ. Энэ номонд судлаач Ба.Батжаргалын хятад хэлнээс орчуулсан “Хуучин тан улсын бичиг”-ийн Түрэгийн шастирын дээд, доод бүлэг, Хуй Хэ-ийн шастирын 145-р бүлэг, Баруун Рун-ын шастирын 148-р бүлэг, Бэй Ди-ийн шастирын 149-р бүлгүүдийн хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Л-63

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18741-18743



Мин улсын судар: Тайзү хааны уг тэмдэглэл / Хятад хэлнээс орч. Д.Ундрах, Ч.Содбилэг.- УБ.: Содпресс, 2017.-122х.- ISBN 978-99929-24-70-9.

Д.Ундрах, Ч.Содбилэг нарын хятад хэлнээс орчуулан толилуулж буй энэхүү “Мин улсын судар”-ын эхний 3 дэвтэр нь Мин гүрнийг үндэслэгч Жу Юаньжан-ы хаанчлалын бүрэн цадиг бөгөөд тэргүүн дэвтэр нь 1328-1368 оныг хамарсан бөгөөд Жу Юаньжан-ы уг гарал, бага идэр нас, Улаан алчууртны бослогод хэрхэн оролцож улмаар бослогын нэгэн толгойлогч болж, Монголын Юань гүрний Хятад дахь ноёрхлыг унаган Мин гүрнийг байгуулсан тухай, дараагийн 2 дэвтэр нь түүний 1368-1398 он хүртэлх 30 жилийн хаанчлалын үед болсон онц чухал үйл явдлуудыг он, сар, өдрөөр нь дараалан бичжээ. Мөн энэ номонд сурвалжийн тайлбар, нангиад эхийг хавсаргажээ.

63.3(5Хят)

М-55

/НУН унш-7, ШУС-ХУС-5ш/

Б-24831-24833

Мэргэн сайд, нэрт түүхч А.Амар: Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд / Эрхл. Ж.Болдбаатар, Ч.Батдорж.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 164х.- (ШУА-ийн түүх, археологийн хүрээлэн).- ISBN 978-99978-0-035-0.



Монгол төрийн нэрт зүтгэлтэн, алдарт түүхч А.Амарын мэндэлсний 130 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг 2016 он 9-р сарын 15-нд зохион байгуулсан бөгөөд энэ хурлаар “Мэргэн сайд, нэрт түүхч Агданбуугийн Амар академич”, “Шинэ эргэлтийн бодлого ба А.Амар”, “Шинжлэх ухааны хүрээлэн ба А.Амар”, “БНМАУ-ын ерөнхий сайд А.Амар”, “А.Амар сайдын өрх амаа өсгөх ухаалаг байр суурь”, “Монгол Зөвлөлтийн харилцан туслалцах протокол ба А.Амар”, “Монгол төрийн гарамгай зүтгэлтэн А.Амарын дурсгалыг мөнхжүүлэх талаар хийж буй ажил” зэрэг 10 гаруй илтгэлийг хэлэлцжээ.

63.3(1)-8

М-97

/НУН унш-5ш/

Б-24746-24748



Содбилэг Ч. Монголын Их Юань улсын түүх / Хян. А.Пунсаг, М.Баярсайхан.- УБ.: Бемби сан, 2010.- 490х.- ISBN 978-99929-7881-3.

Энэ номонд Их Юань улсын түүхийг Юань улс байгуулагдахаас өмнөх үе 1215-1260 он, Хубилайн хаанчлал 1260-1294 он, Өлзийт Төмөр, Хайсан хүлэг, Аюурбарвад хааны үе 1294-1320 он, Юань улсын улс төрийн хямрал 1320-1332 он, Тогоон төмөр хааны үе 1333-1368 он гэсэн түүхэн үечлэлд хуваан авч үзсэн бөгөөд Юань улсын түүхэнд холбогдох монгол, хятад сурвалж бичгийн тойм, зарим нэг алдарт хүмүүсийн намтар, хаад хатадын хөрөг, засаг


захиргааны тогтолцоо, нийгмийн анги давхарга, соёл, хууль цааз, гадаад харилцааны талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторант, Монголын түүх судлаач нийт уншигчдад зориулан толилуулж байна.

63.3(1)43

C-52

/НУН унш-5, ГНОФ-2ш/

T-18666-18668



Фань Э. Хожуу Хан улсын бичиг: Ухуань, Сяньбийн, Өмнөд Хүннүгийн, Баруун орны шастир / Орч. Ба.Батжаргал; Ред. П.Дэлгэржаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 88х.- ISBN 978-99978-4-272-5.

Хожуу Хан улсын бичиг нь Гуан У Ди-гийн Жиан У-гийн анхдагч /МЭ25/ оноос Хан Шань Ди-гийн Жан Ань-ийн 25 /МЭ220/ он хүртэлх 195 оны үйл хэргийг багтаасан сурвалж бөгөөд арван боть үндсэн тэмдэглэл, наян бүлэг намтар шастиртай ажээ. Энэ номонд судлаач Ба.Батжаргалын хятад хэлнээс орчуулсан “Хожуу Хан улсын бичиг”-ийн Ухуань Сяньбийн шастир, Өмнөд

Хүннүгийн шастир, Баруун орны шастирыг хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Ф-21

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

T-18744-18746

Хөвсгөлийн хязгаарын түүх, соёлын зарим асуудал: Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл / Эмхт. Г.Анхсанаа; Ред. Э.Жигмэддорж.- УБ.: Арвайбархан, 2016.- 161х.- ISBN 978-99978-4-176-6.

Энэхүү эмхэтгэлд МУИС-ийн түүхийн тэнхим, УБ хот дахь Хөвсгөл аймгийн Хатгалын нутгийн зөвлөл хамтран 2015 оны 4-р сард зохион байгуулсан “Хөвсгөлийн хязгаарын түүх, соёлын зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцсэн Хөвсгөл аймгийн нутаг дахь эртний түүх, археологийн судалгаа, буган хөшөө, Хүннүгийн морь дагуулсан оршуулга, задын тухай, Хөвсгөлийн хязгаарын түүхэнд холбогдох баримт, Хаант Орос Урианхайн асуудал, ардын журамт цэргийн анхны хороо, цагдаагийн алба үүссэн түүх зэрэг 10 гаруй илтгэлүүд оржээ.

63.3(1-M17)+72

X-53

/НУН унш-5, ШУС-ХУС-2ш/

T-18726-18728



Хятад дахь монгол судлал: Цуврал 1-3 / Эрхл. Д.Базардорж, Б.Лхагвадорж; Ред. Чимэддорж.- УБ.- (Монгол-Хятадын соёлын харилцааг дэмжих нийгэмлэг).

БНХАУ-д суралцаж буй монгол улсын судлаач магистрант, докторант нар Өвөрмонголын их сургуулийн Монгол судлалын бүтээлүүдийг орчуулан, өөрийн орны судлаач нарт цуврал болгон толилуулж байна. Энэхүү цуврал 1-д Монголын эртний, дундад ба орчин үеийн түүхтэй холбогдолтой монголчуудын угсаа язгуур, Татарын тухай, урианхай, халха баргын үүсэл, Галдан бошигт хаан, Харчин гурван хошууны газар, цагаач иргэд нутагшсан тухай; цуврал 2-т Чингис хаан, Цахарын түүх, Лигдэн хаан, Халхын Сэцэн хан аймаг, Сэцэн хаан, Галдан бошигт хааны захидал, Чин улс, үхэр жилийн үймээн, Бор тайж, монголч эрдэмтдийн товч намтар, цуврал 3-т монгол бичиг, “Нууц товчоо”-ны үгсийн хэлбэр, монгол ба түрэг хэлний адилавар үгс, Монголын орчин үеийн уран зохиол, Хөх хот ба Өвөрмонголын түүх, Равжамба зая бандида, Дибба Арбубагийн захидал, Алунгоо эх, ван Гончигсүрэнгийн тухай судалгааны өгүүлүүд тус тус оржээ.

63.3(1)

/НУН унш-3, ШУС-ХУС-3ш/


X-99

Цувр.1.- 2013.- 290х.- ISBN 978-99962-826-4-5.

T-18729-18731

Цувр.2.- 2013.- 325х.- ISBN 978-99962-826-8-3.

T-18732-18734



Чянь Сы Ма. **Түүхэн тэмдэглэл, Хүннүгийн шастир** / Орч. Ба.Батжаргал; Ред. П.Дэлгэржаргал.- УБ.: Удам соёл, 2016.- 110х.- ISBN 978-99973-3577-7. Сы Ма Чяньны “Түүхэн тэмдэглэл” бүтээл нь үндсэн тэмдэглэл 12, он дарааллын хэлхээс 10, сэдэвчилсэн түүхэн найруулал 8, сурвалжит өрхийн цадиг 30, намтар шастир 7, нийт 130 боть, 52 саяаас дээш ханз үсгийн багтаамжтай, баялаг агуулга бүхий нэвтэрхий түүх ажээ. Энэ номонд судлаач Ба.Батжаргалын хятад хэлнээс орчуулсан “Түүхэн тэмдэглэл”-ийн

Хүннүгийн шастирыг хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Ч-99

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18747-18749

Шоу Чэн. **Уван, Сяньби, Зүүн И-ийн шастир** / Орч. Ба.Батжаргал; Ред. С.Сэргэлэн.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 36х.- ISBN 978-99978-4-270-1.



Жаран жилийн түүхийг өгүүлэх “Гурван улсын ойллого” бүтээл нь хамгийн анхандаа “Вэй улсын ойллого”, “Шу улсын ойллого”, “У улсын ойллого” гэсэн 3 номоор нийгэмд тархжээ. Тухайн үедээ Жин улс нь Вэй улсыг залгамжлан хятадыг нэгтгэсэн учир, “Гурван улсын ойллого”-д Вэй улсыг төв болгон бичсэн ажээ. Энэ номонд судлаач Ба.Батжаргалын хятад хэлнээс орчуулсан “Гурван улсын ойллого”-ийн 30-р бүлэг Уван, Сяньби, Зүүн И-гийн шастирыг хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Ш-81

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18738-18740



Энхбаатар Л. **Нэрт монгол судлаачид** / Хян. О.Содномпил.- УБ.: Мөнх Арьяа, 2015.- 340х.- ISBN 978-99962-3-431-6.

Хэл бичгийн эрдэмтэн Х.Лувсанбалдангийн 90 жилийн ойд зориулан түүний хүү Л.Энхбаатарын хэвлүүлсэн энэ номонд монгол судлаач Бичурин, И.М.Ковалевский, П.И.Кафаров, М.В.Певцов, П.К.Козлов, Ербатский, Самандабадра, В.В.Бартольд, Эрик Хэниш, Б.Я.Владимирцов, Н.П.Шастина, Г.Д.Санжеев, Йорген Бич, Шар Дамдинсүрэн, Ре багш,

Т.Пагба зэрэг 40 гаруй хүний товч намтар, ажил үйлсийн талаар, мөн зарим нэг хүмүүстэй хамтран ажиллаж байсан аавынхаа дурсамжуудаас өгүүлжээ.

63.3(1)-8

Э-66

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18678-18680

Эрдэнэбаатар Д. **Хүн улсын соёлын өв=The cultural heritage of Xiongnu empire**: МЭӨ IV зуун-МЭ 93 он: Монгол, англи хэл дээр / Хян. Го.Аким, Л.Батчулуун.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 238х.- (ШУА. УБИС-ийн археологийн тэнхим).- ISBN 978-99973-29-87-5.

Энэхүү зурагт тайлбар номонд Хоёр мянган жилийн тэртээд өнөөгийн Монгол нутагт оршин байсан аугаа их Хүн /Хүннү/ улс нь оюун санаа, аж ахуйн хөгжлийн хувьд Евразийн асар том хүчирхэг гүрэн байж, Өрнө, Дорны улс орнуудтай улс төр, эдийн засгийн нягт холбоотой байсан тухай батлан харуулсан олон баримтуудыг түүвэрлэн, Хүн улсын хаад язгууртны оршуулга болон хойлоглох зан үйлийн соёл, Хүннүгийн алт, мөнгө, хүрэл эдлэлүүд ба ахуйн эдлэлүүд хэмээн 2 бүлэг, 6 хэсэгт хуваан, өнгөт зургийн хамт оруулжээ. Энэ ном нь Монголын нэн эртний түүх, тэр дундаа Хүннү улсын талаар сонирхон судлагч нийт уншигчдад гарын авлага болох ажээ.

63.5(1)





Янь-шоу Ли. **Умард төрийн түүх**: Түрэг, Тэ лэ / Орч. Ба.Батжаргал; Ред. Ц.Баттулга.- УБ.: Удам соёл, 2015.- 48х.- (Corpus scriptorum. Tomus XII).- ISBN 978-99973-73-49-6.

“Умардын түүх” нь нийтийн тооллын 386 оноор эхэлж нийтийн тооллын 618 оноор төгсөх, умард төрийн Вэй улс, умард Чи улс, Зүүн Вэй, Сүй улс гэх 4 улсын 233 оны түүхийг багтаасан 99 боть бүтээл ажээ. Энэ номонд судлаач Ба.Батжаргалын хятад хэлнээс орчуулсан “Умардын төрийн түүх”-ийн 87-р боть болох түрэг судлалтай холбогдолтой “Түрэг, Тэ лэ” шастирын

хятад, латин, крилл галигуудыг давхар хадаж оруулжээ.

63.3(5Хят)

Я-60

/НУН унш-5, ШУС-ХУС-4ш/

Т-18756-18758

ЭДИЙН ЗАСАГ

Бурмаа Н. **Төрийн байгууллагын чанарын удирдлага**: Сурах бичиг.- УБ., 2017.- 352х.- ISBN 978-99978-0-279-8.

Энэхүү сурах бичигт чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээс эхлээд гэрчилгээ авах хүртэлх алхмууд, үйл явцын удирдлага, шаардлагатай баримт бичгүүд, удирдлагын үүрэг, хариуцлага, ажилтнуудын хүлээх үүргийг тодорхой жишээн дээр тулгуурлан тайлбарлажээ. Мөн сурах бичигт шинжлэх ухааны тогтсон мэдлэг, ухагдахууныг тайлбарлан хүргэхээс гадна чөлөөтэй сэтгэх, харьцуулах, цаашид судлах, хэрэгжүүлэх асуудлуудыг дэвшүүлжээ.

65.290-2

Б-75

/Цахим сан-1ш/



Бурмаа Н., Andree U. **Хөрөнгө оруулалт**: Сурах бичиг.- УБ., 2017.- 370х.- ISBN 978-99978-4-117-9.

Шийдвэр гаргах түвшний болон хөрөнгө оруулалт, худалдан авалт, санхүү, төсөв, нягтлан бодогч, мөн энэ чиглэлээр сурч, ажиллаж буй хүмүүст зориулагдсан энэ номонд хөрөнгө оруулалтын ухагдахуунуудыг эдийн засгийн үр ашгийн судалгаа, дүн шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явц, зардлын дансны код боловсруулах, ашиг тусыг тодорхойлох, эдийн засгийн үр ашгийн шинжилгээний аргууд, шийдвэрлэх утга тодорхойлох зэрэг 10 бүлэгт хуваан шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж, бодит кейс дасгалаар жишээ авч тайлбарлажээ.

65.26-56

Б-75

/Цахим сан-1ш/



Коносүкэ М. **Бизнесийн амжилт хүнээс**: Бизнес дэх хүний хүчин зүйл / Ред. Х.Цэвэлмаа; Орч. Т.Одгэрэл, Ч.Ундрам, Ж.Гансүх ба бус.- УБ.: Тоонотпринт, 2016.- 167х.- ISBN 4-569-53704-9.

Тухайн байгууллагын амжилт нь хүний нөөцөөсөө хамааран тодорхойлогддог. Бизнесийн өсөлт нь ажилтнаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд шаардлагатай ажлыг гүйцэтгэх ур чадвартай хүн байгаа эсэхээс шууд хамаарна. Хичнээн гайхамшигтай арга барил, байгууллагын соёл шилдэг технологи, үйлчилгээ нэвтрүүлсэн ч эдгээр талыг нь өндөр хэмжээнд, тогтвортой байлгах ур чадвартай нөөцгүй бол бизнес аажимдаа мөхнө. Тиймээс бизнесийн байгууллагууд хүний нөөцийн хөгжлийн асуудал болох сонгон шапгаруулалт, сургалт

хөгжил, ажилчдынхаа авъяас чадварыг бүрэн ашиглах асуудлыг чухалчлан авч үздэг. Байгууллагын хүний нөөцийг системтэйгээр хөгжүүлснээр компанийн гүйцэтгэл, ашиг орлого нэмэгддэг нь нэгэнт батлагдсан.

65.290-2

К-64

/НУН-унш-4, ГОФ-3, БС-5ш/

Б-24793-24795

Мизес Л.Ф. **Эдийн засгийн бодлого**: Эдүгээ хийгээд ирээдүйн тухай бодрол / Орч. Б.Оюунчимэг; Ред. Д.Амартүвшин, Н.Хасар.- УБ.: Нэпко, 2017.- 116х.- ISBN 978-99973-49-91-0.


Эдүгээд ч ирээдүйд ч хэрэгжүүлэх эдийн засгийн оновчтой бодлого тун энгийн байна. Төр ард иргэдийнхээ амь нас болон өмч хөрөнгийг дотоодын болон гадаадын түрэмгийллээс хамгаалах маргааныг шийдвэрлэх, мөн хүмүүсийг өөрийн зорилго хэрэгцээнийхээ төлөө ажиллаж, амьдрах нөхцөлийг хангаж чөлөөтэй орхих ёстой. Энэ бол төрийн оролцоо гаарсан манай эринд бол радикал санаа юм. Өнөөдөр бид үйлдвэрлэлийг зохицуулж, хянах, зарим бүтээгдэхүүн болон үйлчилгээний үнийг өсгөж, нөгөө нэгнийх нь үнийг бууруулах цалингийн хэмжээг тогтоох, тодорхой нэг бизнесийг дэмжиж дампуурахаас аврах, экспорт, саад хийх өвчтэй болон ахмад хүмүүст анхаарал халамж үзүүлэх зэрэг хамаг л асуудлаа төрөөр зохицуулах гэдэг нийгэмд амьдарч байна.

65

М-52

/НУН унш-7ш/

Б-24796-24798



Сонинтамир Н., Энхтуул Н. **Стратегийн хэрэгжүүлэлт**: Төлөвлөгөөнөөс бодит амжилтанд хүрэх нь.- УБ.: МУИС., 2016.- 136х.- ISBN 978-99973-3-179-3.

Зохиогчид энэ номондоо зах зээлийн харилцаа өндөр хөгжсөн орнуудын аж ахуйн нэгж, байгууллагуудын стратегийн бодлого, түүний хэрэгжүүлэлтийг хангах арга хэрэгсэл, механизмуудын талаарх онол арга зүйн үндсийг бүрдүүлж буй асуудлуудыг нарийвчлан авч үзсэний зэрэгцээ стратегийн хэрэгжүүлэлтийг хангах үндсэн асуудлууд, хэм хэмжээ, стандартуудыг бодит практик, үндэслэлд тулгуурлан оновчтой зөв, ойлгомжтойгоор тайлбарлаж, шинэ санал санаачлагыг дэвшүүлжээ. Энэхүү бүтээл нь байгууллагын удирдах түвшний ажилтан бүрийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх ширээний ном, амжилтын хөтөч болох юм.

65.290-2

С-57

/НУН-унш-3, БС-10ш/

Б-24834-24835



Чимгээ Д., Эрдэнэчимэг Ж. **Бизнесийн мэдээллийн систем** / Ред. Д.Хонгорзул, Б.Энхтуул.- 2 дахь хэвл.- УБ., 461х.- ISBN 978-99962-4-522-0.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологи асар хурдацтай хөгжиж нийгмийн бүхий л салбарт мэдээллийн технологи нэвтэрч бизнесийн байгууллагууд мэдээллийн технологийн шилдэг шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна. Энэхүү сурах бичиг нь агуулгын хувьд бизнесийн байгууллагын мэдээллийн систем, байгууллага мэдээллийн технологи ашиглан өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, мэдээлэл харилцаа холбооны технологийн үндсэн ойлголт, мэдээллийн ёс зүй ба аюулгүй байдал, электрон бизнес, өгөгдлийн сангийн удирдлага, өгөгдлийн агуулах, нийлүүлэлтийн гинжин хэлхээний удирдлага, хэрэглэгчтэй харилцах удирдлага, байгууллагын нөөц төлөвлөлтийн систем, мэдээллийн системийн хөгжүүлэлт гэсэн бүлгүүдийг багтаасан өргөн хүрээтэй цогц бүтээл юм.

65.290-2

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Коммунизмын хар ном / Стефан Куртуэ, Николл Верт, Жан-Луи Панне ба бус; Орос хэлнээс орч. Я.Дүгэр; Ред. Р.Банзрагч.- УБ.: Хөх монгол принтинг, 2013.- 630х.- ISBN 978-99929-2-651-X.


Энэ номыг зохиогч түүхч эрдэмтэдийн баг 20-р зууны хүн төрөлхтөнд энгүй их гамшиг, сүйрэл авчирсан хүрэн тахал-фашизмаас өмнө үүсч, түүнээс удаан оршин тогтнож, дөрвөн тивд халдварлан ардаа үй түмэн хүний аймшигт эмгэнэл, нийгмийн хоцрогдол, ёс суртахууны гажуудал үлдээсэн “улаан тахал”-коммунизмын гэмт хэргүүдийг тодорхой баримттайгаар дэлгэн харуулж, даян дэлхийн эмгэнэл болсон, коммунизмын далбаан дор үйлдэгдсэн гэмт хэргүүдийг энэ номонд тодорхой баримттайгаар өгүүлжээ.

66.1(0)

К-63

/НУН унш-5, ГНОФ-2ш/

Т-18681-18683



Трамп Д., Макивэр М. **Би хэзээ ч бууж өгдөггүй**: Хүндрэл бэрхшээлийг хүсэн хүлээсэн ололт амжилт болгох нь / Ред. Б.Гэрлээ, В.Уянга; Орч. Б.Гэрлээ.- Анхны хэвл.- УБ.: Нэпко, 2017.- 236х.- ISBN 978-99978-51-00-0.

АНУ-ын Ерөнхийлөгч Трампын өөрийн үзэл бодлын тухай өгүүлсэн энэхүү номонд тэрээр “...Энэ номонд би өөрт хамгийн ойр дотно тэр л зүйлийн тухай буюу юунд ч хэзээ ч бууж өгдөггүй зан чанарынхаа тухай өгүүллээ.

Амьдралд юу ч тохиолдсон аясаар нь урсахгүй байх тэр л чанарын тухай ярихад хүрвэл арвин туршлагатай хүн магадгүй үгүй биз ээ. Тийм ч учраас энэ талаар өгүүлэх эрхтэй хүн гэж өөрийгөө санах юм. Би хэд хэдэн ном бичсэн, тэгээд ч мөнгө надад сонин биш болжээ. Гэлээ ч туйлбартай зан чанарын тухай ярихад илүүдэхгүй гэж үзэж байна. Иймээс энэ тухайд тусгайлан өгүүлбэл зүйд нийцэх биз ээ...” хэмээжээ.

66.3(7АНУ)8

Т-61

/НУН-унш-4, ГОФ-3, БС-1ш/

Б-24828-24830

ХУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААН



Дундын өмчлөлийн эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа / Боловс. С.Даваадорж, Б.Бурмаа; Хян. А.Дугармаа.- УБ.: Содпресс, 2016.- 54х.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь дундын ба гэр бүлийн эд хөрөнгийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт, дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах шийдвэр, барьцааны зүйлээс төлбөр гаргуулах тухай асуудлуудыг хамарчээ.

67.401я7

3-32

/ХЗС-5ш/

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа / Боловс. Д.Лхагвасүрэн, Д.Эрдэнэтуяа; Хян. Ц.Цогт.- УБ.: Содпресс, 2016.- 84х.


“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь захиргааны шийдвэр, түүний төрөл, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүний гүйцэтгэх ажиллагаа, биелэлт, гадаад улсын захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хариуцлагын талаарх асуудлуудыг хамарчээ.



67.404.1я7

Д-65

/ХЗС-5ш/



Золбоо Т. **Эрүүгийн эрх зүй: Гэмт хэргийн бүтээц** / Ред. Ж.Эрдэнэбулган.- УБ.: Адмон, 2016.- 183х.- ISBN 978-99973-3-699-6.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Т.Золбоогийн энэхүү бүтээл нь эрүүгийн эрх зүй, түүн дотроо гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн талт элемент бүхий уламжлалт ойлголтыг онол, үзэл баримтлалын өөр чиг хандлагаар авч үзсэн бөгөөд Герман болон Европын зарим улс орнуудад хэрэглэдэг гэмт хэргийн бүрэлдэхүүний онолд тулгуурлан бичжээ. Энэхүү ном нь шинэ эрүүгийн хуулийн онолын суурь ойлголтыг тайлбарлахад чиглэгдсэн бөгөөд хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, багш, судлаачдад зориулагджээ.

67.411

З-64

/ХЗС-5ш/

Зөрчилдөөний менежмент, хэлэлцэх ур чадвар / Боловс. Л.Энхжаргал, Ю.Оюунаа; Хян. Т.Алтангэрэл.- УБ.: Содпресс, 2015.- 72х.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь зөрчилдөөн гэж юу болох, зөрчил үүсэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх, харилцааны төрөл, харилцах ур чадвар эзэмших, хэлэлцээрийн төрөл, харилцан ашигтай хэлэлцээр хийх арга зам, бусдад нөлөөлөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь тулгамдсан асуудлуудыг хамарчээ.

67.404я7

З-77

/ХЗС-5ш/



Мэргэжлийн ёс зүй: Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл / Хян. Ж.Амарсанаа; Эрхл. Б.Өлзийсайхан.- УБ.: ХЗҮХ., 2017.- 444х.- (Билиг дээд сургууль).- ISBN 978-99978-800-00.

Ёс зүйн дүрэм нь аливаа байгууллагын алба хаагчдын өдөр тутам баримтлах зан үйлийн журам бөгөөд энэ нь эрх зүйн актаар баталгаажсанаар заавал биелүүлэх эрх зүйн үр дагаврыг бий болгож байдаг. Мөн түүнчлэн их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй, Мэргэжлийн ёс зүй, Хуульчийн ёс зүй зэрэг хичээлийг зааж судалж буй багш, оюутан, магистрантуудад чухал хэрэглэгдэхүүн болох юм.

67+87.75

М-97

/ХЗС-1ш/

Одгэрэл П. **Татварын эрх зүйн ерөнхий анги: Захиргааны ерөнхий хууль ба Татварын ерөнхий хууль** / Хян. Г.Алтанзаяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 176х.- (МУИС. ХЗС. Нийтийн эрх зүйн тэнхим).- ISBN 978-99978-0443-3.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн нийгмийн тогтолцоонд шилжснээр 1992 оны 12 дугаар сард татварын багц хууль гэсэн 5 хууль батлагдсанаар татварын эрх зүйн өнөөгийн тогтолцооны суурь тавигдсан билээ. Энэхүү бүтээлийн онцлог нь Монгол улсын татварын эрх зүйн ерөнхий ангийг германы эрх зүйн онол үзлийг түшиглэн захиргааны эрх зүйн агуулгад нийцүүлэн боловсруулж, татварын ерөнхий хуульд тусгавал зохих шинэ сэргэг санаа, үзлийг гаргах оролдлого хийсэнд оршино.

67.402

О-19

/ХЗС-20ш/





Үндсэн хууль ба эрх зүйт ёс-VIII: Илтгэлийн эмхэтгэл / Эмхт. А.Түвшинтулга.- УБ.: ХЗҮХ., 2017.- 158х.- (МУИС. ХЗС. ХЗҮХ. Үндсэн хуулийн цэц. Эрх зүйт сан. Ханнс Зайделийн сан. Монголын хуульчдын холбоо).- ISBN 978-99978-0-378-8.

Энэхүү эмхэтгэлд 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулсан Монгол Улсын Төр, нийгмийн зүтгэлтэн, Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Ач-Хариад Бяраагийн Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаанд шалгарсан арав гаруй хууль судлаач, хуулийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын илтгэлүүдийг эмхэтгэн толилуулжээ.

67.400.1

Ү-82

/ХЗС-5ш/


ХБНГУ-ын иргэний хууль: Кодификацийн бүрэн эх / Орч. Б.Буянхишиг.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 456х.- (МУИС. ХЗС. Хувийн эрх зүйн тэнхим).- ISBN 978-99973-79-14-6.

ХБНГУ-ын иргэний хууль 1896 онд батлагдсанаасаа хойш дэлхийн олон орны иргэний хуульд жишиг, жишээ болсоор ирсэн ба Монгол улсын одоогийн иргэний хуульд ч тодорхой нөлөө үзүүлдэг ажээ. ХБНГУ-ын хувьд хувийн эрх зүйн харилцааг иргэний төрөлжсөн хуулиас гадна худалдааны төрөлжсөн хуулиар зохицуулдаг ба энэ 2 хууль хоорондоо салшгүй холбоотой, харилцан уялдаатай байдаг байна. ХБНГУ-ын 1896 оны иргэний хуулийн бүрэн орчуулгыг 2002 оны 1-р сарын 2-ны байдлаар нийтэд хүргэсэн иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсан шинэчилсэн хувилбараар нь хууль зүйн чиглэлээр сурч буй оюутан, багш, судлаач нарт толилуулж байна.

67.404(4Гер)

Х-42

/ХЗС-15ш/



Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, шаардах эрхээс төлбөр гаргуулах ажиллагаа / Боловс. Б.Батболд, Я.Батгэрэл, Б.Алтангэрэл; Хян. Т.Алтангэрэл.- УБ.: Содпресс, 2015.- 84х.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь хөдлөх эд хөрөнгийг илрүүлэх, хөдлөх эд хөрөнгө барьцаалах хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулах, шаардах эрх, үнэт цааснаас төлбөр гаргуулах ажиллагааны талаарх асуудлуудыг хамарчээ.

67.404.1я7


Х-55

/ХЗС-5ш/

Хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампуурал / Боловс. П.Хадбаатар, С.Бямбарагчаа; Хян. У.Мөнхбат, Л.Энхбилэг.- УБ.: Содпресс, 2016.- 62х.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь дампуурлын тухай ойлголт, авах арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх, нэхэмжлэл, хүсэлт тэдгээрийн ялгаа, хүчин төгөлдөр бус хэлцэл, дахин хөрөнгөжүүлэх ажиллагааны ойлголт, дампуурсанд тооцож татан буулгах, шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны талаарх асуудлуудыг хамарчээ.

67.402я7





Эвлэрлийн гэрээ, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудсыг гүйцэтгэх ажиллагаа / Боловс. Б.Дашдаваа, Д.Эрдэнэтуяа; Хян. Т.Алтангэрэл, А.Дугармаа.- УБ.: Содпресс, 2015.- 56х.


“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд хэвлүүлсэн энэхүү гарын авлага нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны зарчим, арбитраар маргаан шийдвэрлэх ажиллагаа, гадаад улсын арбитрын ажиллагаа, нотариатын мэдэгдэх хуудасны агуулга ба шаардлага, эвлэрлийн гэрээ, албадан гүйцэтгэх нийтлэг журам ба ажиллагааны төрлийн талаарх асуудлуудыг хамарчээ.

67.410я7

Э-13

/ХЗС-5ш/

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ



Олон улсын харилцаа: Эрдэм шинжилгээний бичиг: №1/32(458) / Эрхл. С.Баттулга.- УБ.: МУИС., 2017.- 253х.- (МУИС-ийн ОУХНУС).- ISSN 2308-8125.

Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургуулиас эрхлэн гаргадаг энэхүү сэтгүүл нь олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын эрх зүй, бүс нутаг, орон судлалын чиглэлээр Монголын болон гадаадын эрдэмтэд, судлаачдын үзэл бодол, санал шүүмж, судалгааны ажлын үр дүнг уншигч олонд хүргэх зорилготой эрдэм шинжилгээний бүтээл юм. Энэ удаагийн эрдэм шинжилгээний бичигт 20 орчим судлаачдын бүтээл оржээ.

72+66.4

О-29

/Лав.-1ш/

T-18663

Орчуулгазүй: №03,04,05 / Эрхл. Г.Элдэв-очир.- УБ.: Удам соёл.- ISSN 2313-6170.

“Орчуулга зүй”-н цуврал бүтээлийн №03-т ардын аман зохиолыг англи хэлэнд орчуулсан, орос яруу найраг дахь угсаа соёлын нэр, буруу орчуулгаас үүдсэн буруу нэршил, монгол хэлц үгийн орос орчуулга, нэр томъёог оновчтой хэрэглэх, монгол япон хэлний нийлмэл өгүүлбэр, орчуулгын шүүмж судлал, шүлэг орчуулах эрдэм; №04-т яруу найргийн орчуулга зүйтэй холбогдолтой хятадын эртний яруу найраг орчуулах, монгол ардын дууг орос хэлэнд хөрвүүлэх, Сергей Есенинийг би хэрхэн орчуулав, монгол хэлнээ орчуулсан түркийн уран зохиол, хаикү шүлгийн орчуулга, зохист аялгууны онол ба монгол орчуулга, энэтхэг яруу найраг; №05-д Монголын үе үеийн орчуулагч О.Адьяа, Б.Банзрагч, А.Бямбаноров, Н.Доржготов, Чой.Лувсанжав, Г.Лувсан, Б.Энэбиш нарын бүтээл туурвилууд, герман-монгол монгол-герман орчуулгын бүтээл, солонгос, япон, хятад, орос, испани, франц, итали зохиолчдын бүтээлийн монгол орчуулга, уран зохиолын орчуулгын тухай өгүүллүүд тус тус оржээ.

72+81.2

/НУН унш-5ш/

О-49.

№03.- 2014.- 163х.- ISBN 978-99973-49-29-3.

T-18810-18811

№04/422/- 2015.- 184х.- ISBN 978-99973-7324-3.


T-18812-18814

№05/452/- 2016.- 268х.- ISBN 978-99973-7324-3.

T-18815-18817

Хайгуулчин: Үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний сэтгүүл: №57 / Эрхл. ред Г.Сэрсмаа.- УБ.: Сэлэнгэпресс, 2017.- 173х.- (Монголын үйлдвэрлэлийн геологчдийн холбоо).- ISBN 976-

99978-0-497-6.



Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбооны санаачилгаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монгол улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль зэрэг байгууллагууд хамтран энэхүү “Монголын геологи, хайгуул-2017” чуулга уулзалтыг зохион байгуулж, уг чуулгаар монголын геологичдын хөдөлмөрийн үр шим, мэргэжилтний дуу хоолой, технологи, туршлага, үр дүнг танилцуулах, судлаачдын илтгэл, мэдээлэл сурталчилгааг солилцсон үр өгөөжтэй хамтын ажиллагаа бэхжин буйг харуулсан уулзалт болжээ.

72+26.3

X-16

/ШУС-БУС-2ш/



Эрх зүй: NUM Law review: Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл: 2016 №4: Цуврал 36.- УБ., 2016.- 238х.- ISSN 2226-9037.

МУИС-ийн Хууль зүйн сургуулиас эрхлэн гаргадаг цуврал сэтгүүлийн энэ дугаарт Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдал, өрсөлдөөний эрх зүй, мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг, нийтийн ба хувийн эрх зүй, оюуны өмч, нотолгооны эрх зүй, нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх ажиллагаа, эрүүгийн, иргэний ба захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний талаарх судалгаа-эрдэм шинжилгээний өгүүллүүд оржээ.

72-67

Э-81

/ХЗС-3ш/

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Батхуяг С. ба бус. **Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник:** Судалгаа яаж хийх вэ? / Б.Төртогтох, Н.Цогзолмаа.- УБ.: Хүслийн өнгө, 2015.- 277х.- ISBN 978-99962-938-56.

Магистрант, докторант болон судалгааны ажлын арга барил эзэмшихийг хүсч буй уншигчдад зориулагдсан энэ номонд орчин үеийн боловсрол судлалын онол арга зүй ба судалгааны ажлын онцлог, судлан шинжлэх ажлын ерөнхий зүй тогтол, арга зүйн ерөнхий зарчим шаардлага, төлөвлөлт, судалгааны үндсэн арга, мэдээлэл цуглуулах аргууд, эмпирик аргаар цуглуулсан мэдээллээ боловсруулах, эрдэм шинжилгээний бүтээлийн төрөл, бичиж боловсруулах ажлын соёл, судалгааны чанарыг хэрхэн үнэлж үр дүнг боловсролын практикт яаж нэвтрүүлж хэрэгжүүлэх талаар өгүүлжээ.

74.0

Б-34

T-18664-18665



СЭТГҮҮЛ ЗҮЙ



Зулькафиль М. **Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн судалгааны арга зүй:** Боть 6 / Ред. Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн.- УБ.: Удам соёл, 2017.- 300х.- ISBN 978-99978-4-323-4.

Зохиогч орчин үеийн монголын сэтгүүл зүйн асуудлыг түүхэн уламжлал, туршлагад тулгуурлан онол, практик, арга зүйн үүднээс цаг хугацаа, орон зайн өргөн хүрээнд судалж дүгнэлт хийжээ. Бүтээлийн нэг, хоёрдугаар бүлэг нь судалгааны ажлын талаарх ерөнхий ойлголт, тавигдах шаардлага, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн судалгааны ерөнхий асуудлуудад зориулагдсан бол; гуравдугаар бүлэгт туршилтын судалгааны үндсэн үе шатууд, түүний ерөнхий дэг журам; дөрөвдүгээр бүлэгт судалгааны тусгай салбарууд; тавдугаар бүлэгт

нийгэм-хүмүүнлэгийн салбар шинжлэх ухааны аргуудыг түлхүү хэрэглэдэг хандлагуудын талаар өгүүлсэн.

76.0

3-80

/НУН-унш-7, ШУС-НУС-5ш/

Б-24802-24804



Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь.- ӨМӨЗО.: Өвөрмонголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2016.- 402х.- ISBN 978-7-5665-0998-7.

Энэхүү бүтээлийг зохиогчийн зөвшөөрлөөр, Өвөрмонголын их сургуулийн сонин мэдээ хэвлэлийн ухааны салбар ба МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн сэтгүүл зүйн тэнхим “Сэтгүүл зүйн нэр томъёоны хадмал толь” хэмээх судалгааны төслийн бүтээлийг хамтран эмхэтгэн гаргажээ. Уйгаржин монгол бичгээр хэвлэгдэн гарсан энэхүү сэтгүүл зүйн тайлбар

толийг өвөг дээдсийнхээ уламжлалт бичиг үсгийг дээдлэн суралцаж буй оюутнуудад зориулжээ.

76.01я2

3-80

/НУН-унш-3, ШУС-НУС-3ш/

T-18764-18765

Сэтгүүлчийн ёс зүйн тухай өгүүллүүд: Эмхтгэл / Эмхт. Ч.Чойсамба.- УБ.: Удам соёл, 2016.- 133х.- ISBN 978-99962-55-62-5.

Зохиогч 2004 онд профессор М.Зулькафилийн хамт “Сэтгүүлчийн ёс зүй” нэг сэдэвт зохиол, мөн онд бие даан “Сэтгүүлчийн ёс зүйн алдаа” гарын авлага хэвлүүлсэн ба эдгээр бүтээлдээ сэтгүүлч хүн мэргэжлийн ур чадвартай, ёс зүйн хэм хэмжээтэй, нийгмийн хариуцлагатай байх шаардлагыг хангах тухайг өгүүлсэн юм. “Сэтгүүлчийн ёс зүйн тухай өгүүллүүд” хэмээх энэхүү эмхтгэлд сэтгүүлчийн ёс зүйн асуудлаар судлаач, сэтгүүлчдийн бичсэн 20 гаруй өгүүллийг түүвэрлэн оруулжээ.



76.01

С-97

/НУН-унш-3, ШУС-НУС-5ш/

Б-24809-24810



Чойсамба Ч. Өмнөд Солонгосын хэвлэлийн түүх / Ред. Б.Болд-Эрдэнэ.- УБ.: Удам соёл, 2016.- 151х.- ISBN 978-99973-948-5-9.

МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимийн багш сэтгүүл зүйн доктор, дэд профессор Ч.Чойсамба “Өмнөд Солонгосын хэвлэлийн түүх” хэмээх энэхүү бүтээлийнхээ эхний бүлэгт тус улсын хэвлэлийн түүхийг үндэсний анхны хэвлэлүүд, Японы дарлалын үеийн хэвлэл, Өмнөд Солонгосын хэвлэлийн үүсэл, цэргийн дарангуйллын үеийн хэвлэл гэсэн агуулгын хүрээнд бичсэн ба дараагийн бүлгүүддээ 1990-ээд оны хэвлэл, 21-р зууны хэвлэл гэсэн түүхийн он цагийн үе шатлалаар хэвлэлийн түүхийг өгүүлжээ.

76.1(5CoӨ)

Ч-75


/НУН-унш-3, ШУС-НУС-10ш/

Б-24805-24806

МУЗЕЙ СУДЛАЛ

Богд хааны ногоон дара эх шүтээнүүд: Өндөр гэгээн Занабазарын түмэн өлзий гийсний 380 жилийн ойд өргөн барив / Хян. О.Мэндсайхан; Англи хэлэнд орч. Ч.Хатанбаатар.- УБ.: Битпресс, 2015.- 87х.- ISBN 978-9997-375-38-4.

Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж буй өндөр гэгээн Занабазарын ухааны ур, мэлмийн ур, мутрын урын дүнд бүрэлдэн бий болсон алдарт Ногоон Дара Эх шүтээнийг нандин шүтээнийхээ үүднээс ч тэр, урлагийн бүтээлийнхээ хувьд ч тэр монгол түмний шашин, соёлын




охь шимийн дээд гэдэгтэй маргах аргагүй юм. Энэхүү цомогт XVII зуунаас XX зууны эхэн үеийг хүртэлх цаг үед хамаарах 80 орчим ногоон Дара Эх бурханы шүтээн дүрийг толилуулсан ба эндээс Өндөр гэгээний хийц, түүний дэг сургууль, Их хүрээ хийц, түүнчлэн долнуур, төвд, хятад хийцийн аргаар бүтээсэн танка зураг, зээгт наамал, загал зураг, цутгамал хөөмөл, шуумал, бар зэрэг дүрслэлийн олон янзын арга барилыг илтгэх нандин шүтээнүүдийн урлалыг сонирхон үзэх болно.

79.1(1)+86.35

Б-52

T-18777-18779



Богд хааны ордон музей (1926-2016): Баримт бичгийн эмхэтгэл / Эрхл. Х.Мэндсайхан; Хян. О.Мэндсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 564х.- ISBN 978-99973-45-63-9.

1924 оны 5 дугаар сарын 20-нд VIII Богд Жибзундамбыг таалал төгссөний дараа Засгийн Газрын комиссын шийдвэрээр Ногоон сүмд байсан янз бүрийн сонин эд өлгийн зүйлийг музейд үзмэр болгохоор шилжүүлэн авчээ. Улмаар 1926 оны 3 дугаар сарын 17-нд Судар бичгийн хүрээлэнгийн дөрөвдүгээр хурлаас “Ногоон лаврин”-г засуулж, музей болгохоор тогтоосон байна. Энэхүү эмхэтгэлд Үндэсний Төв Архивт буй Богд хааны ордон музейтэй холбогдох Засгийн Газар, Соёлын Яам, Музейн Удирдах Газрын тогтоол, тушаал, үзмэр худалдан авсан актууд, үзмэрийн тодорхойлолт, жилийн эцсийн тайлан, Богд хаан, Эх дагина Дондогдулам, Цагаан дарь Гэнэнпил нарын талаарх баримтуудыг түүвэрлэн оруулжээ.

79(1)

Б-52

T-18786-18788

Богд хааны ордон музей үзмэрийн дээжис: 1911-2011 Үндэсний хувьсгалын 100 жилийн ойд өргөн баривай / Хян. Д.Бат-Эрдэнэ, О.Мэндсайхан; Орч. Г.Дэлгэрмаа; Тайлбар Д.Алтаннавч.- УБ., 2011.- 293х.- (Наран гэрэлт түмэн наст Богд хааны ордон музей. “Хоржийлоо” сан. “Ажнай” Корпораци).- ISBN 978-99929-61-96-1.


Богд хааны ордон музейд Өндөр гэгээн Занабазараас эхлэн дараа үеийн Богдуудын эдэлж хэрэглэж байсан зүйлүүд, Өндөр гэгээний өөрийн мутрын урлалууд, Их хүрээний 30 аймгийн гол шүтээнүүд, шашны зан үйлийн эд өлөг, хаан хатан, хутагт хувилгаад, ноёд дээдсийн тамга тэмдэг, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, Монгол урлалын уран дархан, зээгт наамал, торгон зураг, хатгамал, сийлбэр, шуумал, наамал, зүмбэр, цутгамал, ном судар зэрэг тухайн үеийн Нийслэл хүрээ болон Богдын ордонд байсан шилмэл, өөрийн гэсэн өнгө төрх, бэлгэдэл, онцлог түүхээ илэрхийлсэн хосгүй үнэт үзмэрүүд тус музейн сан хөмрөгт хадгалагддаг. Эдгээр хосгүй үнэт үзмэрүүдээс шилдэг төрөл зүйлүүдийн төлөөлөл болгон анхаарал татсан үзмэрүүдийг энэхүү цомогт оруулжээ.

79.1(1)

Б-52

/ШУС-ХУС-1ш/

T-18780-18782



Богд хааны ордон музей үзмэрийн дээжис / Хян. О.Мэндсайхан; Орч. Г.Дэлгэрмаа; Тайлбар Д.Алтаннавч.- УБ. 2013.- 114х.- (Наран гэрэлт түмэн наст Богд хааны ордон музей)

Богд хааны ордон музейд Өндөр гэгээн Занабазараас эхлэн дараа үеийн Богдуудын эдэлж хэрэглэж байсан зүйлүүд, Өндөр гэгээний өөрийн мутрын урлалууд, Их хүрээний 30 аймгийн гол шүтээнүүд, шашны зан үйлийн эд өлөг, хаан хатан, хутагт хувилгаад, ноёд дээдсийн тамга тэмдэг, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, Монгол урлалын уран дархан, зээгт наамал, торгон зураг, хатгамал, сийлбэр, шуумал, наамал, зүмбэр, цутгамал, ном судар зэрэг тухайн үеийн

Нийслэл хүрээ болон Богдын ордонд байсан шилмэл, өөрийн гэсэн өнгө төрх, бэлгэдэл, онцлог түүхээ илэрхийлсэн хосгүй үнэт үзмэрүүд тус музейн сан хөмрөгт хадгалагддаг. Эдгээр хосгүй үнэт үзмэрүүдээс шилдэг төрөл зүйлүүдийн төлөөлөл болгон анхаарал татсан үзмэрүүдийг энэхүү бэсрэг цомогт оруулжээ.

79.1(1)

Б-52

/ШУС-ХУС-1ш/

T-18783-18785


Шинийн наймны Цагаан дара эх: Богд Хааны Ордон Музейн 90 жилийн ойд зориулав / Хян. О.Мэндсайхан; Англи хэлэнд орч. Ч.Хатанбаатар; Тайлбар Ц.Гүнчин-Иш.- УБ.: Битпресс, 2016.- 80х.- ISBN 978-999737569-8.

Энэхүү цомогт Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагддаг XIX зуунаас XX зууны эхэн үеийг хүртэлх цаг үед хамаарах 50 гаруй Цагаан дара эх бурханы шүтээн дүрийг дэлгэн толилуулжээ. Дэлхийн бурханы шашны урлагт жинтэй байр суурь эзлэх Өндөр гэгээний дэг сургууль, Их хүрээ хийц, түүнчлэн долнуур, төвд, хятад хийцийн аргаар бүтээсэн танка зураг, зээгт наамал, загал зураг, цутгамал, хөөмөл, шуумал, бар зэрэг дүрслэлийн олон янзын арга барилаар илэрхийлсэн нандин шүтээнүүдийг нэгэн дороос үзэх, мэдрэх, харьцуулан үзэх, судлан шинжлэх боломжтой юм.

79.1(1)+86.35

III-65

T-18774-18776



Эрх сүрийн бэлгэдэл тамга: Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд зориулсан цуврал үзэсгэлэнгийн эмхтгэл / Эрхл. М.Энхбаатар, Ц.Ганбаатар ба бус.; Хян. О.Мэндсайхан.- УБ.: Үсэг, 2011.- 32х.- ISBN 978-99962-891-70.

Монголын төр ёс, шашин соёлын түүхэнд тамга нь чухал байрыг эзэлдэг. Түүхийн үеүдэд монголчуудын урлан бүтээж, өвлөн уламжлуулж хэрэглэсээр ирсэн тамга, тэмдэг болон тэдгээртэй холбогдох бусад эд өлгийн зүйлс, дардас зэрэг нь Монгол улсын төдийгүй хүн төрөлхтөний түүх соёлын чухаг өвийн тоонд зүй ёсоор орох билээ. Энэхүү гайхамшигт өвүүдийг хааны, төрийн сайдуудын, хутагт хувилгаадын мутрын, аж ахуйн гэхчилэн хамаарах эзэн, зориулалтаар нь, монгол бичиг, дөрвөлжин бичиг, хятад бичигтэй гэхчилэн бичиг үсгийн талаас нь олон янзаар ангилан хувааж болох ба судлаач, сонирхогчдод тэдний судалгааны ажилд нь тус дөхөм болохын үүднээс зөвхөн тухайн тамгыг товч тайлбартай нь толилуулжээ.

79.1(1)+63.5

Э-94

/ШУС-ХУС-1ш/

T-18789-18791

ХЭЛ ШИНЖЛЭЛ



Равдан Э. **Олон хэлний хэв шинжийн судлал=Language typology** / Хян. В.Батмаа, С.Долгор, Ш.Туяа ба бус.- УБ.: Удам соёл, 2017.- 247х.- (МУИС. ШУС-ХУС).- ISBN 978-99978-4-324-1.

Олон хэлний хэв шинжийн судлал нь орчин цагийн хэл шинжлэлийн суурь дэвсгэр төдийгүй тэргүүлэх чиглэл юм. Энэ номонд “Олон хэлний хэв шинжийн судлал”-ын асуудлуудыг олон хэлний хэв шинжийн судлал нь бие даасан чиглэл болох тухай, олон хэлний түгээмэл шинж чанар, хэл ярианы бүтцийн бүрэлдэхүүн, өгүүлбэр дэх үгийн дараалал, өгүүлбэрийн хэв шинж, хэл зүйд хэл ярианы үйлдлүүд тусах, дэлхийн олон хэлэн дэх үйлдлүүдийн бүтэц хэмээх долоон бүлэгт хуваан авч үзжээ.

81

P-13

/НУН унш-7, ШУС-ХУС-8ш/

T-18771-18773

Мөнхцэцэг Т. ба бус. **Япон орон судлал**: Тэргүүн дэвтэр / Д.Майсүлд, Э.Батжаргал; Ред. Ц.Дэлгэрэхцэцэг.- УБ.: Удам соёл, 2016.- 133х.- (МУИС. ШУС-ХУС. Ази судлалын тэнхим).- ISBN 978-99962-52-66-2.



“Япон орон судлал” цуврал сурах бичиг нь япон хэл сурч буй монгол оюутнуудад япон хэлээр нь дамжуулан япончуудын түүх, нийгэм, соёлоос суралцах боломж олгож байгаагаараа онцлог ажээ. Энэхүү тэргүүн дэвтэрт японы газар нутаг, уур амьсгал түүний онцлог, уламжлалт хийгээд орчин үеийн орон сууц, хувцас, хоол, шашин шүтлэг, баяр наадам, урлаг, спортын талаар оруулж, мөн 2000 гаруй үгийн дуудлагыг хадаж, утгыг монголчилсон нь оюутнуудад яриа, үгийн сан, орчуулга, найруулан бичих дадлын хичээлд гарын авлага болох ажээ.

81.2Яп

М-81

/НУН унш-2, ШУС-ХУС-8ш/

Т-18768-18770



Шагдарсүрэн М. **Анагаах ухааны англи-монгол толь**: А-Z / Ред. До.Цэнджав, Ж.Раднаабазар.- УБ.: Сэлэнгэ пресс, 2016.- 1026х.- ISBN 978-99929-0-301-5.

Англи хэлний зохих мэдлэгтэй, анагаах болон эрүүл мэндийн шинжлэх ухааны оюутнууд, залуу эмч эрдэмтэд, судлаач нарт зориулагдсан анагаах ухааны энэхүү толь бичигт нэр томъёог англи цагаан толгойн дэс дарааллаар байрлуулж, тэмдэг нэрээр толгойлж, нэр үгийг ард нь бичиж

оруулжээ.

81.2Англ-4+5

Ш-15

/БУН унш-6, Лав-1ш/

Б-24743-24745

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Нямсүрэн Ц. **Монгол, Грек туульсын бүтцийг харьцуулан судалсан нь**: Хан харангуй, Илиада, Жангар, Одиссей туулийн жишээн дээр / Ред. Б.Дагзмаа, С.Дулам.- УБ.: Үсэг хоршоо, 2017.- 197х.- ISBN 978-99978-0-297-2.


Зохиогч Монгол, Грек туульсын бүтцийг Хан харангуй, Илиада, Жангар, Одиссей хэмээх 4 туульсаар төлөөлүүлэн, эдгээр туульсын бүтцийн адилсал, ялгааг харьцуулан тодруулах гол зорилгодоо тулгуурлан Монгол, Грек домог зүйг бүтэц задлалын аргаар харьцуулан судалжээ. Туульсын хувьд философи категорийн ач холбогдолтой ойлголтуудыг олж, ардын аман зохиолоос өөрийн гэсэн философи дүгнэлт хийх бололцоо байгааг судлаач энэхүү бүтээлээрээ харуулжээ.

82

Н-98

/НУН унш-3ш/

Т-18794-18795



Байгалсайхан С., Болормаа Д. **Бөхийн Бааст**: Намтар, уран бүтээлийн товчоон / Ред. С.Байгалсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 94х.- (ШУА. Хэл зохиолын хүрээлэн. XX зууны монгол зохиолчид-18).- ISBN 978-99962-75-77-7.

“XX зууны монгол зохиолчид” цувралын энэ удаагийн 18 дахь дугаарт Монгол улсын Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Бөхийн Баастын намтар, уран

бүтээлийн тойм болон зохиолчийн Монголын уран зохиолын хөгжилд оруулсан хувь

нэмэр, бүтээлийн уран сайхны туурвилзүйн онцлогийн талаар оруулж, Б.Баастын бүтээлийн жагсаалт, гэрэл зургийн цомгийг хавсаргажээ.

83.3(1)

Б-17

/НУН унш-4, ШУС-ХУС-3ш/

Б-24786-24787

Батжаргал Д. **Чулууны хэл**: Энэрэхүйн цуврал: Монгол, англи хэл дээр / Хян. Б.Хишигсүх, О.Сундуй; Орч. А.Оюунгэрэл.- УБ.: Сэлэнгэпресс, 2013.- 24х.- ISBN 978-99962-4-176-5.


Монгол, англи хэл дээр бичигдсэн, англи хэл сурч буй хүүхэд залуучууд, оюутан нарт зориулагдсан энэ номонд жирийн нэгэн жаалхүү жижигхэн одой болж жишимгүй их сандарсан тухай жигтэй түүхийг өгүүлжээ.

83.8

Б-33



/ШУС-ХУС-5ш/



Батжаргал Д. **Шүлэг яаж бичих вэ?** / Ред. Б.Энхтүшиг.- 3 дахь хэвл.- УБ.: Жиком пресс, 2016.- 160х.- ISBN 99929-76-50-0.

Хүүхэд, залуучуудад зориулагдсан энэ ном нь шүлэг яаж бичих вэ?, есөн цацал, найрагчийн эрхэмлэх хорин нэгэн зарчим гэсэн 3 бүлэгтэй ба уншигчдад илүү ойлгомжтой байлгах үүднээс асуултад хариу өгөх маягаар бичжээ. Мөн түүнчлэн зарим нэг найрагчтай хийсэн товчхон ярилцлагыг багтаажээ.

83.

Б-33

/НУН унш-3, ШУС-ХУС-5ш/

Б-24811



Батсуурь Г. **Ц.Дамдинсүрэн**: Уламжлал шинэчлэл / Ред. Д.Галбаатар, Г.Галбаяр.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 260х.- ISBN 978-99978-0-160-9.

Энэ номонд Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлүүдийг тэр дотроо яруу найраг, туульсын зохиолын уламжлал шинэчлэл, мөн монгол ардын аман зохиолын уламжлал, эртний бичгийн зохиолын уламжлал нөлөөллийн талаас нь судалжээ.

83.3(1)

Б-34

/НУН унш-4, ГНОФ-2, ШУС-ХУС-3ш/

Б-24786-24787

Баттөр Ш. **1990-ээд он**: Монголын уран зохиолын шинэ хандлага / Ред. С.Байгалсайхан.- УБ.: Жиком пресс, 2017.- 96х.- ISBN 978-99978-4-229-4.


1990-ээд онд Монгол улсад өрнөсөн өөрчлөн байгуулалт, нийгмийн хийгээд сэтгэлгээний хувьсгал, чөлөөт байдлыг дагаад уран зохиолын туурвилзүй, судалгаа шинжилгээнд шинэ арга, үзэл баримтлал бий болжээ. Энэ номонд тухайн үед монголын уран зохиолд орсон өөрчлөлт шинэчлэлтийг 1990-ээд оны үеийн яруу найраг, хүүрнэл ба жүжгийн зохиол, судлал шүүмж, 2000-аад оны уран зохиолын тойм хэмээн ангилан судалжээ.

83.3(1)

Б-34

/НУН унш-5, ШУС-ХУС-2ш/

Б-24776-24778



Гаадамба Ш. **Зохиолчийн хөдөлмөрийн тухай** / Ред. С.Байгалсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2014.- 345х.- (МҮЧЗХ. Га багшийн номын сан-1).- ISBN 978-99973-70-05-1.

Их эрдэмтэн зохиолчийн 90 насны ойгоор түүний бүтээлүүдийг цувралаар хэвлэх ажлын хүрээнд энэхүү "Утга зохиолын онолын товчийн тайлбаруудыг" буюу "Зохиолчийн хөдөлмөр" номыг уншигч олноо хүргэж

байна. Энэ номонд зохиолчийн хөдөлмөрийн тухай хувийн сэтгэмж, утга зохиол судлал, шүүмжүүд, сурталчилгааны өгүүллүүд, илтгэл, мөн утга зохиолтой холбогдолтой орос хэлнээс орчуулсан орчуулгын бүтээлүүд нь оржээ.

83.3(1)

Г-10

/НУН унш-7, ШУС-ХУС-5ш/

Т-18718-18720

Гаадамба Ш. **Утга зохиолын онолын товч, Утга зохиолын онолын үндэс** / Эмхт. Г.Билгүүдэй; Ред. С.Байгалсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2014.- 423х.- (МҮЧЗХ. Га багшийн номын сан-1).- ISBN 978-99973-70-04-4.

Зохиолч Ш.Гаадамба дэлхийн урлаг сайхны гоо зүй, онол сэтгэлгээний тусгал болсон оросын эрдэмтэн Г.Л.Абрамовичийн "Утга зохиолын онолын үндэс" хэмээх бүтээлийг цувралаар орчуулан "Цог" сэтгүүлд хэвлүүлж эхэлсэн ба энэхүү онолын ойлголтуудыг монгол хөрснөө буулган монгол жишээ баримтаар баталгаажуулан 1958 онд "Утга зохиолын онолын товч" хэмээх алдарт бүтээлээ туурвисан байдаг. 1989 онд энэ бүтээлээ дахин засварлан "Утга зохиолын онолын үндэс" нэртэйгээр хэвлүүлжээ. Их эрдэмтэн зохиолчийн 90 насны ойгоор түүний бүтээлүүдийг цувралаар хэвлэх ажлын хүрээнд энэхүү "Утга зохиолын онолын товч", "Утга зохиолын онолын үндэс" хэмээх 2 бүтээлийг нэгтгэн уншигч олноо хүргэж байна.




83.3(1)

Г-10

/НУН унш-7, ШУС-ХУС-5ш/

Т-18721-18723



Гадаадын утга зохиолын судлал шинжлэлийн өгүүллүүд: Цуврал-9 / Орч. С.Энхбаяр; Ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2016.- 267х.- ISBN 978-99973-72-84-0.

"Гадаадын утга зохиолын лекцүүд" цуврал номны энэхүү 9-р ботид утга зохиол судлаач, шүүмжлэгч доктор, профессор С.Энхбаярын орчуулан, түүвэрлэсэн Дэйна Жойяа "Өнөөдөр америкийн яруу найраг ямар байдалтай байна вэ?", Н.Е.Черткова "Зөн билиг нь уран сайхны сэтгэлгээний нэг гол хүчин зүйл мөн", Н.Е.Синин "Марина Ивановна Цветаева", Е.В.Хализев "Утга зохиолын эрэмбэ дараалал ба алдар суу", Л.С.Дампилова "Б.Галсансүхийн сэтгэл хөдлөлийн өнгө аястай яруу найраг", А.Белый "Тарас Бульба бол оргилсон эх оронч дайчин сэтгэлийн эмгэнэл мөн", С.Энхбаяр "Сампилдэндэв багшийгаа дурсахуй" зэрэг урлаг, уран зохиолын судлал шинжлэлийн 10 гаруй өгүүллүүд оржээ.

83.3(3)

Г-13

/НУН унш-3ш/

Б-24823-24824

Гэндүнчойпэл А. **Кама Сутра** / Төвд хэлнээс орч. Б.Идэрбаяр.- УБ.: Тоонотпринт, 2015.- 100х.- ISBN 978-99962-972-6-7.

Уг бүтээлийг төвд хэлнээс орчуулсан Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх ШДС-ийн Урлахуйн ухааны салбарын багш Б.Идэрбаяр номын төвд эхийг лам А.Баясгалангаас залж чухал увидасыг номлосон гайхамшигт шастарыг орчуулан уншигч олондоо хүргэж байна. Уг зохиол төвд шүлгийн ёсоор бичигдсэн бөгөөд утгын оньсыг өчүүхэн далдалсан, Төвд хэлний нутгийн аялгууны чухаг нандин үгсээр чимэглэсэн яруу өгүүлэхийн элдэв чимгээр найруулсан, бүтцийн хувьд шүлгийн мөр харьцангуй урт, яруу сайхнаар дүрсэлсэн гайхамшигт бүтээл юм.



83

Г-93

Б-24813-24814

Дэлгэрмаа Б., Дэлгэрбат Б. **Философи ба уран зохиол** / Ред. С.Лочин, С.Баясгалан,



Б.Мөрөн.- УБ.: Удам соёл, 2016.- 506х.- ISBN 978-99978-0-179-1.

“Философи ба уран зохиол” хэмээх энэхүү номонд уран зохиол нь хэрхэн философитой холбогдож байгаа асуудлуудыг философийн үндсэн ойлголт категориуд, орчин үеийн философи ба уран зохиолын урсгал чиглэлүүд, философи ба уран зохиол гэсэн 4 бүлэгт хуваан авч үзсэн бөгөөд дэлхийн алдартай Нобелийн шагналт зохиолчид, мөн монголын зохиолчдын бүтээлүүдээс ишлэл авч, тайлбарлажээ. Мөн хавсралтанд Нобелийн шагналт болон Пулитцерийн шагналт зохиолчдын нэрсийг оруулж өгчээ.

83.3(0)+87.3

Д-88

/НУН унш-3, ШУС-ХУС-5ш/

Т-18766-18767

Дэлхийн алдартай эмэгтэй зохиолчид: Сод авьяастай хүчирхэг эмэгтэйчүүдийн түүх / Орч.эмхт. Б.Шүүдэрэцэг, Б.Амина.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2017.- 261х.- ISBN 978-99978-0-388-7.


Энэ номонд Сельма Лагерлёф, Сигрид Унсет, Габриэла Мистраль, Дорис Лессинг нарын Нобелийн шагналт 14 эмэгтэй зохиолч болон уншигчдаа байлдан дагуулсан Жэйн Остин, Марина Цветаева, Анна Ахматов, Маргарет Митчел, Айн Рэнд, Мурасаки Шикибу, Анне Франк, Э.Л.Войнич, Эми Тан, Стефани Мейер, Чюн Яао нарын үе үеийн 25 уран бүтээлч, зохиолч эмэгтэйн намтар, уран бүтээлийн товчоон, мөн онч мэргэн үгсийг түүвэрлэн оруулжээ. Цаг үеэсээ түрүүлж сэтгэж чадсан, хувь тавилангийн сорилт, засаг төрийн мөрдлөг хавчлага, амьдралын нугачаанд сөхрөөгүй, хүчирхэг эмэгтэйчүүдийн бахдам амьдрал, тэмцлийн түүхийг уншигч та энэ номноос унших болно.

83.3(0)

Д-89

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24844-24846



Набоков В. **Гадаадын утга зохиолын лекц:** Цуврал-1,2,3,4 / Ред. О.Содномпил; Орч. Ц.Цэнгэл, О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2016.

Владимир Владимирович Набоков (1899–1977) бол XX зууны өрнөдийн уран зохиолын содон төлөөлөгч бөгөөд Орос гаралтай Америкийн зохиолч юм. В.Набоковын зохиол бүтээл нь зайлшгүй унших бүх цаг үеийн сонгодог номын жагсаалтанд бичигдсэн байдаг ажээ. В.Набоковын “Гадаадын утга зохиолын лекц” цуврал номонд түүний Жойсийн “Улисс”, Кафкагийн “Хувирал”, Остеней “Мэнсфилд парк”, Диккенс “Хүйтэн байшин” зохиолуудад задлан шинжлэл хийсэн бүтээлүүд оржээ.

83.3

/НУН унш-3ш/

Н-12 Цувр.1: Жойс “Улисс”.- 183х.- ISBN 99973-72-83-3.

Б-24815-24816

Цувр.2: Кафка “Хувирал”.- 95х.- ISBN 99973-72-84-0.

Б-24817-24818

Цувр.3: Остен “Мэнсфилд парк”.- 133х.- ISBN 99978-4-217-6.

Б-24819-24820

Цувр.4: Диккенс “Хүйтэн байшин”.- 143х.- ISBN 99978-4-218-3.

Б-24821-24822

Чойдогжамц Х. **Гүн хэлмэр:** Уран зохиолын судлал, шүүмж / Хян. Л.Нямаа, Г.Батсуурь.- УБ.: Жиком пресс, 2015.- 160х.- ISBN 978-99973-72-98-7.

СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн багш Х.Чойдогжамц судлал шүүмжийн “Гүн хэлмэр” нэртэй номоо хэвлүүлжээ. Тэрбээр өмнө нь уран зохиолын шүүмж, судлалын төрлөөр “Тайлахуйн чинад” хэмээх номоо хэвлүүлж байв. Нэрнээсээ авахуулаад л гүн гүнзгий утга агуулгатай, Монголын утга зохиолын шинэ зууны шүүмж судлалд өөрийн гэсэн орон зайг эзэлж буй энэхүү бүтээлд Монголд бараг үгүй болоод буй театрын шүүмжүүд оржээ. “Хараачлах үнэний бараа буюу Ч.Түвшний “Эдип хаан”, “Байгалийн шинэ жам уу, Шинэ байгалийн жам уу” зэрэг театрын шүүмжүүд нь тайз, үзэгчийн хоорондох харьцааг шинээр



нээж сэтгэлгээний өргөн загвараар боловсруулсан даацтай шүүмжүүд болсон байна.

83.3(1)

Ч-75

Б-24752-24754



Энхбат О. Д.Нацагдоржийн оюуны тэнгэр буюу хас гэрэлтсэн “Харанхуй хад” “Ламбугайн нулимс” / Ред. Д.Нарантуяа, Ц.Мөнхзулцацрах.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 220х.- ISBN 976-99929-73-83-7.

Энэхүү ном нь Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойд зориулан мөн түүний гэргий Нина Ивановна Чистякова болон буурал ээж Б.Дашзэвэгийн гэгээн дурсгалд, Диди Калика Ананда тэргүүнтэй "Бадамлянхуа" хүүхдийн төвийн хамт олонд зориулан эмхтгэн гаргасан бүтээл юм. Их зохиолч Д.Нацагдоржийн оюуны тэнгэр буюу хас гэрэлтсэн “Харанхуй хад”, “Ламбугайн нулимс” өгүүллэгийн дүрслэл, зөн билгийн утга, зохиолуудын онцлог, далд утга, энэ 2 өгүүллэгийн уялдаа холбоо, эрдэмтэн судлаачдын үзэл бодол, эргэцүүлэлүүдийн талаар энэ номонд өгүүлжээ.

83.3(1)

Э-66

/НУН унш-3, ГНОФ-3, ШУС-ХУС-1ш/

Б-24836-24838

УРАНЗОХИОЛ

Батрэгзэдмаа Б. **Очир эрхшээгч**: Роман / Хян. Ц.Оюунчимэг, Б.Сарантуяа; Эмхт. Б.Анар.- УБ.: Адмон принт, 2017.- 493х.- ISBN 978-99973-0-512-1.


Уран зохиол сонирхогч нийт уншигчдад зориулагдсан энэ романд эгэл жирийн нэгэн англи хүмүүн монгол гэгээнтэнтэй учирснаар урьд насандаа эгэлгүй хүчийг олсон лам хувраг хүмүүн явснаа мэдэж улмаар үйлийн үрийн гүн гүнзгий утга, мөнх ба мөнх бусын амьдралыг танин мэдэж, дэлхий ертөнцийн ил далдын гайхалтай явдал, дээд оршихуйн чанадын гайхамшигтай нууцад нэвтрэн, гэгээрлийн хутагтийг олж буй тухай өгүүлжээ.

84(1)-44

Б-34

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18805-18807



Ганболд Ц. **Цэцүүхэй** / Ред. П.Майнбаяр, Д.Нямдорж.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 146х.- ISBN 978-999780-276-7.

Цэвэгжавын Ганболдын энэ номонд “Хонх”, “Хайр”, “Ихрүүд”, “Цэцүүхэй” хэмээх өгүүллэг туужууд оржээ.

84(1)-44

Г-21

Б-24758-24760

Гомбосүрэн Н. **Ухаалаг шийдэл** / Ред. Г.Жамбалсүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 192х.- ISBN 978-99962-3-899-4.

Инженер механикч мэргэжилтэй, орос, англи, япон, солонгос хэлтэй, шүлэг яруу найраг сонирхон оролддог Н.Гомбосүрэнгийн энэ номонд “Сайхан түүхүүд” хэмээх богино өгүүллэгүүд, “Хорвоо” шүлгийн түүвэр, “Санаж авах үгс” хэмээх хоёр мөртүүд оржээ.

84(1)


Г-53

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Б-24770-24772



Лхагвасүрэн Б. **Хүнд манан**.- УБ., 2016.- 296х.- ISBN 978-999292-749-6.



Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн 2016 оны сүүлээр "Хүнд манан" шүлэг, бодролын түүврээ гаргасан. Найрагч 2011 оноос хойш бичсэн шинэ шүлгүүдээ энэхүү түүвэрт багцалжээ. Эл бүтээлд Б.Лхагвасүрэн гуайн 100 шүлэг, кино зохиол багтсан байна.

84(1)-5

Л-87

Б-24761-24763

Норов Д. **Тэжээвэр тэргүүт шилмэл бүтээлийн чуулган**: Тагтаа Пабблишингийн сонголтоор.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 476х.- ISBN 978-99929-67-85-0.

“Тагтаа пабблишинг”-ийн сонголтоор хэвлэгдэн, уншигч таны гар дээр очиж буй энэ ном нь "Мөнхийн ус", "Үхэл хүлээх газар", "Өнийн цэнхэр уулс", "Цээнэ", "Эр хүн" зэрэг 12 өгүүллэг, "Тэжээвэр", "Мөнхийн дуудлага", "Хөх сайрын чулуу" гэсэн гурван туужаас бүрджээ. Д.Норовын өгүүллэг, туужууд хүний дотоод сэтгэлийг төнхсөн нягт бичлэг, сэтгэл зүйн эрс тэс ялгарал, хүүрнэлийн баялаг чанараараа уншигчдад хүчтэй нөлөөлдөг онцлогтой ажээ.

84(1)-44

Н-74

/НУН унш-3ш/

Б-24764-24765



Нямхишиг Х. **Шүлгүүд**.- УБ.: Бит пресс, 2014.- 101х.- ISBN 978-99973-67105.

...Шүлгийг би хэн нэгэн хүнд, аль нэгэн уул овоо, гол усанд, ямар нэгэн цаг үе, үйл явдалд, ялангуяа алга ташилтанд зориулж, тэдгээрийн эрхшээл, таашаалд нийцүүлэх гэж бичдэггүй. Гагцхүү өөртөө л бичдэг. Гэсэн ч хэнд ч, юунд ч эс зориулсан шүлгүүд маань мөн чанартаа бүхий л орон зай хийгээд цаг хугацаанд зориулагддаг...

84(1)-5

Н-98

Б-24755-24757

Содномнамжил Т. **Ганцхан**: Шүлэг, яруу найраг, дурсамж, нийтлэл / Ред. Б.Төгсжаргал, С.Оюунтөгс.- УБ.: Адмон принт, 2017.- 448х.- ISBN 978-99978-4-171-1.


"Зохист дорно" хэвлэлийн газраас яруу найраг сонирхогч уншигчдад зориулан, бурхны шавь, яруу найрагч агсан Тогоонтөмөрийн Содномнамжилын шүлэг найргийн энэхүү "Ганцхан" хэмээх бүтээлийг хэвлэн гаргажээ. Уншигч та энэхүү номноос түүний шүлэг найраг, нийтлэл, түүнд зориулж номын нөхдийнх нь бичсэн дурсамж ярилцлагаас гадна их хайрын тухай унших болно. Т.Содномнамжил бол бүтээл туурвил хийгээд ертөнцийг үзэх үзлээрээ бусдаас илт ялгарах ижилгүй авьяастай нэгэн байжээ.

84(1)-5

С-52

/НУН унш-3ш/

Б-24766-24767



Сономбалжирын Буяннэмэх: 2 боть / Эмхт. Д.Цэдэв, Ван Мандуга; Монгол бичгээс буулг. Д.Болормаа, Д.Сумьяа.- УБ.: Жиком пресс, 2012.

Монгол улсын эрдэмтэн Д.Цэдэв, БНХАУ-ын монголч эрдэмтэн Ван Мандуга нар хамтран Сономбалжирын Буяннэмэхийн мэндэлсний 110 жилийн ойд зориулан энэхүү хоёр боть номыг хэвлүүлжээ. Тус бүтээлийн 1-р ботид С.Буяннэмэхийн намтар, гэрэл зураг, уран бүтээлийн хувь заяа,

мөн түүний яруу найргийн бүтээлүүд, 2-р ботид үлгэр, өгүүллэг, тууж, жүжгийн зохиолууд нь тус тус оржээ.

84(1)

/НУН унш-5, ХУС-2ш/

C-58

Б.1.- 411х.- ISBN 978-99962-58-96-1.

Б-24782-24783

Б.2.- 618х.- ISBN 978-99962-58-97-8.

Б-24784-24785



Фраерман Р. Зэрлэг нохой динго буюу анхны хайрын тууж / Орч. ред. Н.Нансалмаа.- УБ.: Адмон принт, 2016.- 152х.- ISBN 978-99973-0-931-0.

...Жижигхэн хотод амьдардаг Таяа охин үзэж хараагүй улс орны тухай, австралийн динго нохойны тухай мөрөөднө. Холын аялалын оронд хувь заяа түүнийг олон жилийн өмнө эхтэй нь орхин явсан эцэг болон түүний өргөж авсан хүүтэй уулзана... Охины зүрхийг шаналгасан хардах сэтгэл огт санаандгүй байтал халуун, гашуун анхны хайр болон хувирна...

84(2Орос)-44


Ф-82

/ШУС-ХУС-1ш/

Б-24790-24792

Эрдэнэболд С. **Монгол зарчим-1**: Цуцалтгүй тэмүүл / Ред. О.Сундуй, Ц.Гэрэлтуяа, С.Алтантуяа ба бус.- УБ., 2017.- 148х.- ISBN 978-999780180-7.

“Монгол зарчим” ном нь монголын хөгжлийн тухай өгүүлэх цуврал ном ажээ. Эрх чөлөөнд хайртай хүн бүрт зориулагдсан энэхүү цуврал номны 1-р ботид зохиогчийн хаанаас ирсэн, хэн бэ? Тэр өөрийгөө хэрхэн бүтээсэн бэ? Эх орныхоо ирээдүйг ямар хэмжээнд харж, юунд зорьж яваа юм бэ? гэдгийг илтгэсэн танин мэдэхүйн тэмдэглэл, ухаарсан бодомж, учирласан сургаамж үгс, өгүүллэг, шүлэг зэрэг 100 гаруй бүтээл оржээ.




84(1)2

Э-73

/НУН унш-4, ШУС-ХУС-3ш/

Т-18796-18798



Эрдэнэжав ба бус. **Алунгоо эх** / Балжинням, Сэцэн; Монгол бичгээс хөрв. Ц.Өнөрбаян, Б.Шагдаржав.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 214х.- ISBN 978-99978-4-053-0.

Өвөр Монголын судлаач Эрдэнэжав, сурвалжлагч, профессор Балжинням, нэрт зураач Сэцэн нарын хамтын бүтээл “Алунгоо эх хатан”-ы тухай түүхэн романыг монгол бичгээс кирилл үсэгт хөрвүүлэн, уран зохиол сонирхогч нийт уншигчиддаа толилуулж байна.

84(1)

Э-73

/НУН унш-3ш/

Б-24768-24769

ШАШИН СУДЛАЛ, ЁС СУРТАХУУН

Клайв Э. **Буддын шашин** / Ред. Б.Цэнддоо; Орч. Б.Гэрлээ; Тайлбар Ц.Гүнчин-иш.- УБ.: Нэпко, 2017.- 250х.- ISBN 978-99978-51-01-7.

Энэ номд буддын шашинтнууд, тэдний үзэл бодол, үйл амьдралын хэв маягийн тухай өгүүлэх болно. Буддын шашинтай хүмүүс ямар урсгалд шүтэж сүсэглэдэг, хаана аж төрдгөөс хамаараад оюун бодол, ахуй байдал нь харилцан ялгаатай байх ажээ. Гэвч буддын шашинтнууд ерөнхийдөө Төгс гэгээрсэн Буддагийн хоёр мянга таван зуу гаруй жилийн өмнө номлосон тэр л сургаал номлолыг сахиж явдгийг энд онцлон тэмдэглүүштэй.

86.35


К-47

/НУН-унш-4, ГОФ-3, ШУС-ХУС-1ш/

Б-24825-24827



Наполеон Хилл, Клемент Стоун У. **Оюуны эерэг хандлагаар амжилтанд хүрэх нь** / Орч.



А.Хишигсүрэн.- УБ.: Линограф, 2016.- 242х.- ISBN 978-99973-997-0-0.
Дөрвөн хэл дээр орчуулагдан, 3 сая гаруй борлуулагдаж, дэлхийд борлуулалтаараа тэргүүлсэн энэ ном нь зөв хандлагаар хэн ч мөрөөдөлдөө хүрч болно гэдгийг дэлхийд харуулсан бүтээл ажээ.

87.75
Н-29

/НУН унш-4, ГНОФ-3ш/ Т-18672-18674

СЭТГЭЛ СУДЛАЛ

Эрдэнэчулуун Д. **Удирдахуйн сэтгэл судлал.**- УБ.: Ган принт, 2016.- 153х.- (МУБИС. Сэтгэл судлалын тэнхим).- ISBN 99929-62-64-X.

Удирдахуйн талаарх орчин үеийн сэтгэл зүйн онолууд, нэртэй удирдагчын амьдралын түүхэн замнал, амжилтад хүрсэн арга барил, ажлын туршлага, түүнтэй холбоотой баримт сэлт, байгууллагын үйл ажиллагаанд тохиолдож байгаа саад бэрхшээлүүдийг даван туулахад ашиглаж болох, санаа зөвлөмж, удирдагч бие хүний хувийн онцлог, авьяас чадвар, амжилтанд хүрэх арга барилыг тодорхойлох зориулалт бүхий сорил, зан байдал, харилцаа хандлагыг өөрчлөх зөвлөгөөний загваруудыг энэхүү сурах бичигт сонгон оруулжээ. Удирдахуйн сэтгэл зүйн асуудлыг сонирхогч төрөл бүрийн салбарын захирал, зохион байгуулагч, хүнтэй ажилладаг мэргэжилтэн, их дээд сургуулийн оюутнуудад зориулагджээ.



88.5
Э-73

/НУН унш-4, ГНОФ-3ш/

Т-18675-18677

НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ



Болормаа Д. **Монгол утга зохиолын судлал шүүмжлэлийн ном зүй.** 2001-2010 он / Ред. Г.Билгүүдэй.- УБ., 2017.- 448х.- (ШУА. Хэл зохиолын хүрээлэн).- ISBN 978-99973-5143-2.

Энэ бүтээлд ХХI зууны эхний арван жилд монгол утга зохиол судлалаар хэвлэгдэн гарсан ганц сэдэвт зохиол, ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж, бодрол, ярилцлага, сурвалжлага, тэмдэглэл зэргийг эртний ба орчин үеийн утга зохиол, уран зохиолын орчуулга, ном зүйн бүтээл хэмээн 4 бүлэгт хуваан оруулжээ. Энэ ном нь Монголын утга зохиол судлаач нийт уншигчид болон энэ чиглэлээр сурч буй оюутан, магистрант, докторант нарт гарын авлага болох ажээ.

91.9:83
Б-55

/ШУС-ХУС-3, Лав-1ш/

Т-18724-18725

ОРОС, АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ НОМНУУД

Нансалмаа Н. **Лексикология современного русского языка: Теория и практика.**- УБ.: Удам соёл, 2017.- 222с.- ISBN 978-99978-0-271-2.

Предлагаемый учебник содержит материал по теории и практике “Лексикологии современного русского языка”. Русская лексика представлена в четырех больших темах: “Системно-семасиологическая характеристика лексики русского языка”, “Социоллингвистическая систематизация лексики русского языка”, “Фразеология”, “Лексикография”. Каждая тема разбивается внутри на подтемы, вводятся практические задания. Для удобства дается схема анализа. Книга рассчитана на студентов,



изучающих русский язык, также учителей русского языка и на всех тех, кто интересуется богатым миром русского слова.

81.2Рус

Н-25

/ШУС-ХУС-2ш/

С-84785-84789



Данильян О.Г., Тараненко В.М. **Религиоведение**: Учебник.- М.: Изд-во Эксмо, 2007.- 480с.- (Образовательный стандарт XXI).- ISBN 978-5-699-09238-3.

В предлагаемом учебнике в систематизированном виде изложены все наиболее важные и интересные вопросы религиоведения. Особенное внимание уделено каждой из мировых религий: буддизму, христианству, исламу. Учебник написан доступным и одновременно ярким, живым языком. Схемы, таблицы, рисунки а также тематический словарь

способствуют усвоению материала и делают книгу удобной в пользовании.


86.2я7

Д-18

С-84784

Geertz C. **The interpretation of cultures**.- NY.: Basic books, 1973.- 470p.- ISBN 978-0-465-09719-7.


In The Interpretation of Cultures, the most original anthropologist of his generation moved far beyond the traditional confines of his discipline to develop an important new concept of culture. This groundbreaking book, winner of the 1974 Sorokin Award of the American Sociological Association, helped define for an entire generation of anthropologists what their field is ultimately about.



71.0

G-32

/ГФ-1ш/



George D. Chryssides, Ron Geaves. **The study of religion**: An introduction to key ideas and methods.- NY.: Continuum, 2007.- 429p.- ISBN 9780-82646449-1.

Increasingly, recognition is given to the importance of methodology in the study of religion and methodological issues are generally taught to first year students in order to equip them for systematic academic study of the topic. Unfortunately many of the theories that relate to methodology are explained in a highly complex way, which even advanced students find it hard to understand. This book

unravels the complexity of these issues for students by introducing the history and methodology pertaining to the study of religion (including ideas of key theorists) and by discussing the main problems in current scholarship in world religions.


86.2

G-37

/ШУС-ХУС-1ш/

Encyclopedia of new religions: New religious movements, sects and alternative spiritualities / Edit.by Christopher Partridge.- NY.: Lion Hudson, 2004.- 446p.- ISBN 9780-7459-5219-2.


This book gives readers a comprehensive map of the significant religious and spiritual groups functioning in today's world, especially in the West. It is written by specialists but with the non-specialist in mind. The Encyclopedia of New Religions offers an authoritative and lavishly illustrated guide to more than two hundred of these extremely varied groups and movements. The new religions, sects and alternative spiritualities are categorized according to the religious traditions from which they spring. Included are well established groups like the Mormons and the Hutterites, and more recent movements like the Santeria, the Unification Church and ISKCON (the 'Hare Krishnas').



86я2

E-54

/ШУС-ХУС-1ш/



Religions in the modern world: Traditions and transformations / Edit. by Linda Woodhead, Hiroko Kawanami, Christopher Partridge.- 2nd ed.- NY.: Routledge, 2009.- 549p.- ISBN 978-0-415-45891-7.

Comprehensive in its coverage, this completely revised and updated second edition of Religions in the Modern World considers the history and modern practices of the world's main religious traditions. It analyses trends in the manifestation of religion in the modern world, from secularization to the rise of new spiritualities, and is at the cutting edge of developments in the study of religion. This second edition includes new chapters on Religion and Violence, Paganism, Religion and Popular Culture, Spirituality, Secularism and Secularization, discussion of the strength of the Christian Right, case studies and anecdotes, text extracts, chapter menus and end-of-chapter summaries, glossaries and annotated further reading sections, a wide variety of photographs, figures, tables and maps. Religions in the Modern World is the ideal textbook for those coming to the study of religion for the first time, as well as for those who wish to keep up-to-date with the latest perspectives in the field. Fully international in coverage, it is accessibly written by practising and specialist teachers.

86.2

R-41

/ГФ-1ш/

%%%